

## 2004-2008 ОНЫ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

### Анхдугаар хуралдаан

Аймгийн ИТХ-ын 5 дахь удаагийн сонгуулиар аймгийн хэмжээнд нийт сонгогчдын 77,9 хувь нь оролцож 30 төлөөлөгч сонгогдсон байна.

Аймгийн ИТХ-ын Анхдугаар хуралдааныг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 167 тогтоолоор 11 дүгээр сарын 3-ний өдөр хуралдуулж Аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн дүн, аймгийн ИТХ-ын бүрэн эрхийн тухай сонгуулийн хорооны дарга П.Батаагийн илтгэл болон зохион байгуулалтын асуудал хэлэлцэхээр товлон зарлажээ.

Анхдугаар хуралдаанд 30 төлөөлөгчийн 17 төлөөлөгч хүрэлцэн ирж, Эх орон ардчилсан эвсэлээс сонгогдсон 11 төлөөлөгч Жаргалант сумын сонгуулийн хорооноос аймгийн сонгуулийн 25,30 дугаар тойргийн 87,92 дугаар хэсгийн хорооны санал хураалтыг хүчингүй болгосон тул дээрхи 2 тойргийн асуудлыг шийдэж төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрсөн тохиолдолд хуралдаанд оролцохыг мэдэгдэж хуралдаанд ирээгүй байна. Тухайн үед төлөөлөгчийн бүрэн эрхийн асуудлаар санал зөрөлдөж Эх орон ардчилсан эвсэлээс 5 удаа албан шаардлага ирүүлж, 25,30 дугаар тойргийн нэр дэвшигчдийн бүрэн эрхийг зөвшөөрөх, Жаргалант сумын сонгуулийн хорооны тогтоолыг хүчингүй болгох, эвсэлээс сонгогдсон төлөөлөгчид оролцоогүй байхад анхдугаар хуралдааныг хийхгүй байх тухай дурдсан байна. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс эвсэлд хуралдаанд оролцох тухай болон тавьсан шаардлагын хариу болгож 4 удаа албан тоот хүргүүлжээ. Эх орон эвсэлийн 11 төлөөлөгчийг 1 хоног, 1 цаг 30 минут хүлээж 17 төлөөлөгчийн ирцтэй 60,7 хувийн оролцоотойгоор хуралдааны ажиллагааг нээж Анхдугаар хуралдааны даргаар Намсрайн Дамба, нарийн бичгийн даргаар Хабайн Дарьгерхан нарыг сонгосон байна.

Хуралдаан төлөвлөсөн асуудлаа хэлэлцэж нийт 28 төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай тогтоолыг баталсан байна. Аймгийн сонгуулийн 25,30 дугаар тойргийн төлөөлөгчийн асуудлыг зохих хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх хүртэл хойшлуулсан байна. Төлөөлөгчдийн бүрэн эрх зөвшөөрснөөр намын бүлгийг байгуулж Монгол Ардын Хувьсгалт Намын бүлгийн ахлагчаар төлөөлөгч Ц.Баасандорж томилогдсон байна.

Дараа нь зохион байгуулалтын асуудал хэлэлцэж аймгийн ИТХ-ын даргаар Очир овогтой Ширэндэвийг сонгохоор аймгийн МАХН-ын бүлгээс нэр дэвшүүлж, төлөөлөгч 5 хүн асуулт асууж санал хэлсэнээр илээр санал хурааж О.Ширэндэв хуралдаанд оролцсон 17 төлөөлөгчийн 94,1 хувийн саналаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар сонгогдсон байна.

Дараа нь олонхийн бүлгийн ахлагч Ц.Баасандорж 15 минутын завсарлага авч аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийг сонгох ажилд орсон ба бүлгийн дэд дарга Н.Баатарням

тэргүүлэгчдэд төлөөлөгч О.Ширэндэв, Н.Дамба, Х.Дарьгерхан, Д.Батчулуун, Ц.Баасандорж, Л.Батбаяр, Н.Батаа нарын нэрийг дэвшүүлсэн байна. Төлөөлөгчдөөс өөр санал гараагүй тул дээрхи хүмүүсийг тэргүүлэгчээр 100 хувийн саналаар баталжээ.

Хэлэлцэх асуудлын дараалалын дагуу аймгийн ИТХ-ын дэргэдэх Нийгмийн бодлогын, Төрийн байгуулалт, хууль зүйн, Төсөв санхүү, эдийн засгийн бодлогын, Хөдөөгийн бодлого, байгаль орчны, Төсвийн зарлага, санхүүжилтын хяналтын байнгын хэсгүүдийг байгуулжээ.

Хуралдаан аймгийн МАХН-ын бүлгээс аймгийн Засаг даргад Г.Нямдаваагийн нэрийг дэвшүүлж 5 төлөөлөгч асуулт асууж, 5 хүн санал гаргасанаар санал хурааж нийт оролцсон төлөөлөгчдийн 100 хувийн саналаар нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн мэдүүлсэн байна.

### **Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдаан**

Анхдугаар хуралдаанаар аймгийн Засаг даргад Г.Нямдаваагийн нэрийг дэвшүүлэн ерөнхий сайдад өргөн барьсан ч аймгийн ИТХуралд сонгогдсон нам, эвсэлийн төлөөллийг бүрэн оролцуулж шийдвэрлэх нь зүйтэй гэсэн хариу ирүүлсэн тул ээлжит бус хуралдааныг зарласан байна.

Шинээр сонгогдсон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2004 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн 176 тоот тогтоолоор ээлжит бус хуралдааныг 2004 оны 11 дүгээр сарын 16-ны 9,00 цагт хуралдуулахаар зарлаж аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн байна. Ээлжит бус хуралдаанд ирвэл зохих 28 төлөөлөгчийн 16 буюу 57,1 хувь ирсэн тул аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв үг хэлж нээж хуралдааны ажиллагааг эхлэхэд Эх орон Ардчилал эвсэлээс хуралдааны үйл ажиллагаанд оролцохгүй тухай мэдэгдэж ирээгүй байна.

Хуралдаан дэг болон хэлэлцэх асуудал, дотоод журмаа баталж хэлэлцэх асуудлын дараалалын дагуу Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцсэн байна. Өмнөх нэр дэвшүүлсэн анхдугаар хуралдааны шийдвэрт Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ХЭГ—1005 тоот бичиг ирж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал суудал бүхий нам, эвсэлээс зөвшилцөл хийж дахин нэр дэвшүүлэхээр шийдвэрлэсэн тул аймгийн МАХН, Эх орон ардчилал эвсэлээс тус бүр 3 хүний бүрэлдэхүүнтэй зөвшилцөх ажлын хэсэг байгуулагдаж 3 удаа уулзан ярилцсан боловч саналын зөрүүтэйгээр хуралдаанд оролцох, 25,30 дугаар тойргийн төлөөлөгчийн асуудлаар зөвшилцөлд хүрээгүй байна. Анхдугаар хуралдаан болон ээлжит бус хуралдаанд төлөөлөгчдийг бүрэн оролцоог хангахгүйгээр хуралдаан хийж байгааг буруушаасан мэдэгдлийг 2004 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 03 тоотоор Ховд аймгийн Эх орон ардчилал эвсэлээс аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон МАХН-ын гишүүдэд хандаж мэдэгдэл хийсэн байна. Харин Ховд аймгийн МАХН-ын бүлгээс 2004 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 01 тоотоор Эх орон ардчилал эвсэлийн мэдэгдэлд хууль бус шаардлага тавьж хуралдаанд оролцохгүй байгаа тухай дурдаж хариуг хүргүүлжээ.

Ээлжит бус хуралдааны 01 тоот тогтоолоор хуралдааны дэг, хэлэлцэх асуудал, дотоод журмыг баталсан байна.

Зөвшилцөлд хүрч эвслийн бүлэг ээлжит бус хуралдаанд хүрэлцэн ирээгүй тул ээлжит бус хуралдааны ажиллагааг үргэлжлүүлэн хэлэлцэх асуудлын дагуу аймгийн Засаг даргад нэр дэвшүүлсэн байна. Ээлжит бус хуралдааны 2 дугаар тогтоолоор Ц.Жалцав даргатай У.Батзаяа, Н.Баатарням гишүүнтэй тооллогын комиссыг байгуулан ажилласан байна. Аймгийн Засаг даргад МАХН-ын бүлгээс Г.Нямдавааг дахин нэр дэвшүүлж 5 төлөөлөгч асуулт асууж, төлөөлөгч Н.Дамба, Ц.Баасандорж, У.Батзаяа нар үг хэлснээр, илээр санал хурааж хуралдаанд оролцогчдын 100 хувийн саналаар Монгол Улсын Ерөнхий сайдад өргөн барьсан байна.

Аймгийн Засаг даргаар томилуулахаар нэр дэвшүүлэх тухай 4 дүгээр тогтоолыг нийт төлөөлөгчдийн 57,1 хувь буюу хуралдаанд оролцогчдын 100 хувийн саналаар баталсан байна.

Ээлжит бус хуралдааны хуралдаанд үйлчлэх албаны нарийн бичгийн даргаар аймгийн Засаг Даргын Тамгын Газрын ажилтан Б.Шоовдой, Б.Нарантуяа, А.Самданхүү, редакцийн комиссоор Б.Хашэрдэнэ Боловсрол соёлын газрын дарга, Ч.Цэрэнчимэд аймгийн ерөнхий аудиторч, тэмдэглэл хөтлөгчөөр Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан нар ажилласан байна.

Монгол улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Баярцогтоос 2004 оны 1- дүгээр сарын 3-ны өдрийн ХЭГ/1135 тоот албан бичгээр ИТХ-ын бүрэн эрхийг зөвшөөрөхөд нийт төлөөлөгчдийг хуралдаанд оролцуулах, тэргүүлэгчдийн бүрэлдэхүүнийг хуралд нам, эвслийн авсан суудлын тоотой тэнцүү байдлаар бүрэлдүүлэхээр аймгийн ИТХ-ын хуралдааныг 12 дугаар сарын 8-ны дотор хуралдуулж шийдвэрээ Засгийн газарт ирүүлснээр аймгийн Засаг даргад нэр дэвшигчийн томилгооны асуудлыг авч үзэх тухай зөвлөмж чиглэлийг ирүүлсний дагуу аймгийн ИТХ-д суудалтай нам эвслээс хийсэн зөвшилцлийн хүрээнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн 189 тоот тогтоолоор ээлжит бус хуралдаан зарлаж 12 дугаар сарын 6-ний өдөр хуралдуулан аймгийн МАХН-ын хороо, “Эх орон – ардчилал” эвслийн 1,2 дугаар зөвшилцлийг хэрэгжүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн байна. Хуралдаанд аймгийн ИТХ-ын 25,30 дугаар тойргоос бусад 28 төлөөлөгч, урилгаар 10 хүн үүнээс төсөвт байгууллагын ажилтан 6 оролцож, 2 асуудал хэлэлцэн 8 тогтоол гаргасан байна.

Нам эвслээс хийсэн 1,2 дугаар зөвшилцөлд МАХН-ыг төлөөлж Д.Галсандондог, Д.Олдох, Ц.Баасандорж, Н.Батаа, Л.Батбаяр, Эх орон-ардчилал эвслийг төлөөлж З.Хайдав, М.Буяндэлгэр, Ц.Бямбаа, Ч.Лхагважав, Т.Хүдэрчулуун нар оролцсон байна

Нам, эвслийн 2004.12.05-ны өдрийн 1 дугаар зөвшилцлөөр аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 2004.12.06-ны өдөр хуралдуулах, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тоог 9-

ээр тогтоож түүнд МАХН-аас 5, “Эх орон- ардчилал” эвслээс 4 гэсэн харьцаатай байх, аймгийн ИТХ-ын сонгуулийн 25,30 дугаар тойргийн маргаантай асуудал нээлттэй байхаар тохиролцжээ. Харин 2004.12.05-ны өдрийн 02 дугаар зөвшилцлөөр аймаг, сумын ИТХ-ын сонгуулийн дүн, аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай илтгэл сонсож, асууж танилцах, аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай тогтоол хэлэлцэж батлах, аймгийн ИТХ-ын төлөөлөгчөөр сонгогдсон Эх орон-ардчилал эвслийн төлөөлөгчдийн энгэрийн тэмдэг, үнэмлэх гардуулах, Эх орон –Ардчилал эвслээс аймгийн ИТХ дахь бүлэг байгуулсан шийдвэр танилцуулах, аймгийн ИТХ-ын дарга сонгож баталсан тухай тогтоолтой танилцаж санал хэлэх, 1 дүгээр зөвшилцлийн дагуу аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс чөлөөлөх, нэр дэвшүүлэх, сонгож батлах асуудлуудыг тохиролцсон байна.

Ээлжит бус хуралдаанаас хуралдааны дэг, хэлэлцэх асуудал, хуралдааны дотоод журам, ажлын албыг баталсан байна.

Хуралдааны нарийн бичгийн даргаар аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан А.Самданхүү, Б.Нарантуяа, М.Мягмарцог, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Т.Аюушжав, Засаг даргын тамгын газрын ажилтан Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Тооллогын комисс батлах тухай 02 дугаар тогтоолоор комиссын даргаар аймгийн ИТХ-ын Төлөөлөгч Х.Отгонбаяр, гишүүдэд төлөөлөгч Б.Батсүх, Ц.Жалцав нар томилогдон ажиллажээ.

Тус хуралдаанаас аймгийн ИТХ-ын сонгуулийн 25, 30 дугаар тойргийн асуудлыг судалж шийдвэрлүүлэхээр Ч.Лхагважав, Д.Нямлхагва, Х.Отгонбаяр, Ц.Жалцав нарын төлөөлөгчдөөс бүрдсэн ажлын хэсгийг байгуулж ойрын хугацаанд шийдвэрлэх талаар үүрэг болгосон байна.

Хуралдааны 4 дүгээр тогтоолоор төлөөлөгчдийн бүрэн эрхийг төлөөлөгчдийн 60,7 хувь, анхдугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн 100,0 хувийн саналаар зөвшөөрсөн байна.

Төлөөлөгчдийн тойргийн дарааллаар:

1. Сэрээжавын Батхуяг МАХН /БОЭТ-д эмгэг зүйч /
2. Ноостойн Батаа МАХН /аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг төрийн сангийн хэлтсийн дарга /
3. Мархын Буяндэлгэр Эх орон-Ардчилал эвсэл /аймгийн Засаг даргын тамгын газрын санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн /
4. Батбаярын Отгоншар МАХН /Удам уламжлалын эмнэлгийн орлогч эмч/
5. Тэрбишийн Баярсайхан МАХН /Лүточир компаний захирал/

6. Нэргүйн Баатарням МАХН /аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа хууль зүйн хэлтсийн дарга/
7. Цэрэнгийн Жалцав МАХН /аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг төрийн сангийн хэлтсийн орлогч дарга/
8. Батнасангийн Батсүх Эх орон-Ардчилал эвсэл /Алтай трестийн гүйцэтгэх захирал/
9. Санжаан Батмөнх МАХН /Зэрэг сумын Засаг дарга/
10. Халтайн Батболд МАХН /Манхан сумын Төгрөг багийн Засаг дарга/
11. Хэтээн Отгонбаяр МАХН /аймгийн мэргэжлийн хяналтын газрын дарга/
12. Цэдэвийн Мягмардорж МАХН /Ховдын тулга ХХК-ны захирал/
13. Дашзэвэгийн Батболд Эх орон-Ардчилал эвсэл /БОЭТөвийн мэс заслын их эмч/
14. Цэндсүрэнгийн Бямбаа Эх орон-Ардчилал эвсэл /Алтайн аянчин компаний захирал/
15. Хабайн Дарьгерхан МАХН /Ховд сумын Засаг даргын тамгын газрын дарга/
16. Уртнасангийн Батзаяа МАХН /аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга/
17. Очирын Ширэндэв МАХН /аймгийн Засаг даргын орлогч/
18. Намсрайн Дамба МАХН/ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга/
19. Шаравын Батхишиг Эх орон-Ардчилал эвсэл /аймгийн ХААН банкны салбарын захирал/
20. Цагаанцоожын Баасандорж МАХН /МУИС-ийн харьяа Ховд Их Сургуулийн захирал/
21. Ядмаагийн Галбат Эх орон-Ардчилал эвсэл /Баруун бүс төв зах ХХК-ны захирал/
22. Дашцэрэнгийн Нямлхагва Эх орон-Ардчилал эвсэл /Ховд Эрдэм дээд сургуулийн ерөнхий захирал/
23. Лхангаагийн Галбадрах Эх орон-Ардчилал эвсэл /бизнесмен/
24. Лхамсүрэнгийн Батбаяр МАХН /аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга/
25. /Сонгууль маргаантай болсон/
26. Чимэдцэрэнгийн Цэвэгжав Эх орон-Ардчилал эвсэл /Алтайн буян компаний захирал/
27. Тунгаан Хүдэрчулуун Эх орон-Ардчилал эвсэл /Техникийн захын захирал/
28. Чимидцэрэнгийн Лхагважав Эх орон-Ардчилал эвсэл /бизнесмен/
29. Должинсүрэнгийн Батчулуун МАХН /Алтан гар компаний захирал/
- 30./ Сонгууль маргаантай болсон/ нарын бүрэн эрхийг зөвшөөрч анхдугаар хуралдааны 04 тоот тогтоолыг баталгаажуулсан байна.

Эх орон-Ардчилсан эвслээс 13 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй намын бүлгийг байгуулж даргаар нь Ц.Бямбаа, дэд даргаар Л.Галбадрах, Я.Галбат нарыг сонгон баталж хуралдаанд мэдэгдсэн байна.

Хуралдааны 5 дугаар тогтоолоор анхдугаар хуралдаанаас 60,7 хувийн саналаар аймгийн ИТХ-ын даргаар сонгогдсон О.Ширэндэвийг сонгосон тогтоолыг хуралдаанд оролцсон 28 төлөөлөгчийн 100 хувийн саналаар баталгаажуулсан байна.

Хуралдааны 06 дугаар тогтоолоор нам эвслийн зөвшөлцөлийн дагуу МАХН-ын бүлгийн саналыг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээс Д.Батчулуун, Х.Дарьгерхан нарыг чөлөөлсөн байна.

Зөвшөлцлийн дагуу Эх орон-Ардчилал эвсэлээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд Шаравын Батхишиг, Цэндсүрэнгийн Бямбаа, Ядмаагийн Галбат, Чимэдцэрэнгийн Цэвэгжав нарын нэрийг дэвшүүлж 7 дугаар тогтоолоор хуралдаанд оролцсон 28 төлөөлөгчийн 100 хувийн саналаар Очирын Ширэндэв, Намсрайн Дамба, Ноостойн Батаа, Цагааны Баасандорж, Лхамсүрэнгийн Батбаяр, Шаравын Батхишиг, Ядмаагийн Галбат, Цэндсүрэнгийн Бямбаа, Чимэдцэрэнгийн Цэвэгжав нарыг сонгосон байна.

Хэлэлцэх асуудлын дарааллаар аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх асуудлыг хэлэлцэж Эх орон-Ардчилал эвслийн бүлгээс аймгийн ИТХ-ын төлөөлөгч Лханаагийн Галбадрахын нэрийг дэвшүүлж, нэр дэвшигч үг хэлж өнөөгийн төлөөлөлийн байгууллагын нөхцөл боломжийг харгалзан нэрээ татаж Г.Нямдаваад ажлын амжилт хүссэн байна.

Хуралдааны 08 дугаар тогтоолоор анхдугаар хуралдаанаар Гэндэнжавын Нямдавааг аймгийн Засаг даргад нэрийг дэвшүүлж Ерөнхий сайдад өргөн мэдүүлсэн шийдвэрийг ээлжит бус хуралдаанд оролцсон 28 төлөөлөгчийн 100 хувийн саналаар баталгаажуулан Ерөнхий сайдад өргөн мэдүүлснээр хуралдааны ажиллагаа өндөрлөсөн байна.

Хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан давхардсан тоогоор 7 хүн үг хэлж 65 удаа асуулт асууж хариулт авсан байна.

### **Аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 185 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдааныг 2004 оны 12 дугаар сарын гуравдугаар 10 хоногт хуралдуулж

- 1.Аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэлийн тухай илтгэл
2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай илтгэл
3. Аймгийн 2005 оны төсвийн төсөл 2003 оны төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэл
- 4.Аймгийн 2005 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл
5. Газар зохион байгуулалтын тайлангийн урьдчилсан дүн, 2005 онд өмчлүүлэх газрын тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 195 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдааныг 2004 оны 12 дугаар сарын 27-ны өдөр хуралдуулахаар шийдвэрлэж Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухай

илтгэл болон Аймгийн 2005 оны төсвийн төсөл 2003 оны төсвийн гүйцэтгэлийн тухай илтгэлийг нэгэтгэн хэлэлцэхээр тогтсон байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор 2 дугаар хуралдаанд хэлэлцүүлэхээр оруулах “Газар зохион байгуулалтын тайлангийн урьдчилсан дүн, 2005 онд өмчлүүлэх газрын тухай илтгэл”-ийн боловсруулалт бүрэн хийгдээгүй тул хойшлуулан 2005 оны 1 дүгээр сарын 2 дахь хагаст багтаан ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэхээр тогтож газрын албаны ажлыг шалгаж дүгнэлт өгөх, Монгол улсын иргэдэд газар өмчлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, 2005 онд өмчлүүлэх газрын талаар санал боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батбаяраар ахлуулан тэргүүлэгчид, мэргэжлийн байгууллагын байцаагчдын бүрэлдхүүнтэй байгуулан ажилд оруулсан байна.

Хуралдаан “Хуралдааны дэг батлах” тухай 2/1 тогтоолоор аймгийн ИТХ-ын хуралдаанд бэлтгэх журам, хуралдаанд хэлэлцэх асуудлыг бэлтгэх, хуралдаан хуралдах журам, төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх, хуралдаанд урилгаар оролцогчдын эрх үүрэг, хуралдааны шийдвэрийг ёсчлох, нийтлэх, мэдээлэх, хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг ашиглах тухай 7 бүлэг зохицуулалт бүхий хуралдааны дэгийг сонгуулийн эрхийн хугацаанд мөрдөж байхаар баталсан байна.

Хуралдааны ажлын албаны нарийн бичгийн даргаар А.Оюундэлгэр, Б.Нарантуяа Засаг даргын тамгын газрын түшмэл, аймгийн аудитын газрын шинжээч Б.Түмээ, редакцийн комиссоор Б.Шоовдой аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл, Б.Хаш-Эрдэнэ аймгийн Боловсрол соёлын газрын дарга, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг дарга Г.Нямдаваагаар ахлуулан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв “Аймгийн ИТХ-ын 2004-2008 оны эрхийн хугацааны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн тухай” илтгэлдээ “2004 оны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймгийн ИТХ-ын анх дугаар хуралдаанаар болон ээлжит бус хуралдаанаар Төлөөлөгчдийн бүрэн эрхийг зөвшөөрч ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, тэргүүлэгчдийг сонгож аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэн томилуулахаар Монгол улсын Ерөнхий сайдад өргөн барьсан байна.

Аймгийн ИТХ-аар ирэх 4 жилд аймгаа хөгжүүлэх хурлын үндсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь Нутгийг өөрөө удирдах ёсны байгууллагын үйл ажиллагааг идэвхжүүлэх, орон нутгийн бие даасан байдлыг хангах, эдийн засгийн хөгжлийн бодлого, нийгмийн хөгжлийн бодлого, байгаль орчны бодлого, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг 5 дэд бүлэгтэйгээр салбарын баримтлах бодлого, хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон болно.

Ирэх 4 жилд аймаг, сум, багийн хурлын бие даасан байдлыг бүх шатандаа хангах, идэвхитэй хамтын ажиллагааг сайжруулах, дээд шатны хурлаас доод шатны хуралдаа үзүүлэх мэргэжил арга зүйн туслалцааг эрчимтэй нэмэгдүүлэх, хурлын ажлын мэдээлэлийг байнгын болгож хурлын төлөөлөгчид, ажлын албаны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, иргэдэд бодиттой мэдээлэлийг шуурхай хүргэж, төр, иргэдийн холбоог сайжруулах үүсгэл санаачилгыг нэмэгдүүлэх нь ирэх жилүүдийн зорилт бөгөөд, хурлын төлөөлөгчид сонгогчдынхоо захиа даалгаврыг биелүүлдэг, түүний үр дүнг тайлагнадаг, иргэдийн санал, гомдол, үг, зөвлөмжийг сонсдог, түүнчлэн үйл ажиллагаа, ёс суртахуунаараа үлгэрлэн, хурлынхаа үйл ажиллагааны идэвхтэй оролцоогоор хэрэгжих учиртай юм.

Аймгийн эдийн засаг нийгмийн хөгжлийн 2004-2008 оны зорилтыг товчилбол Аймгийн ИТХ, Тэргүүлэгчид нутаг дэвсгэрийнхээ эдийн засгийн асуудлаар бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мал сүргийн тогтвортой өсөлтийг хангах, ХАА-д эрчимжсэн аж ахуй бий болгох, олборлох болон ХАА-н гаралтай бүтээгдхүүн түүхий эдийг үйлдвэрийн аргаар боловсруулах замаар жижиг, дунд болон бүс нутгийн чанартай үйлдвэр бий болгох, эдийн засаг санхүүгийн салбарын тогтворжилтийг бататгах, хувийн хэвшил, тэргүүний технологийг давуутай хөгжүүлэхэд чиглүүлэх тухай тэмдэглэсэн байна.

Илтгэлтэй холбогдуулан 6 хүн үг хэлж тус хуралдааны 2/3 тогтоолоор “Үндсэн чиглэл батлах тухай” тогтоолыг баталсан байна.

“ Засаг даргын 2004-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2005 оны үндсэн чиглэлийн тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа итгэлдээ Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулахдаа орон нутгийн иргэдийн хурлын сонгуулийн үед улс төрийн намуудын дэвшүүлсэн мөрийн хөтөлбөр, сонгогдсон УИХ-ын гишүүд, аймгийн ИТХ-ын төлөөлөгчид, сум, албан байгууллага, ажилтануудын саналд тулгуурлан ойрын жилүүдэд зайлшгүй шийдвэрлэх тулгамдсан асуудлуудыг хэрэгжин биелэх санхүүгийн боломж, нөөцийг харгалзан боловсруулж “Төрийн удирдлага эрх зүй”, “Нийгмийн бодлогын цогц асуудал”, “Санхүү, эдийн засаг, дэд бүтэц, үйлдвэр худалдаа”, “Хүнс, ХАА, байгаль орчны бодлого”, “Гадаад харилцаа, батлан хамгаалах, гамшгийн асуудал” зэрэг 5 бүлэг 16 дэд хэсэг, 225 асуудал тусгасан олон үндэстэн ястан түмнийхээ бүтээлч, дайчин хөдөлмөрч уламжлалд тулгуурлан орон нутгийн давуу тал, дотоод нөөц бололцоо, шинжлэх ухаан, техникийн орчин үеийн ололтыг оновчтой ашиглан, төрийн байгууллагын албан хаагчдын хариуцлага, чадавхийг өндөржүүлж, аймгийнхаа эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх, ард иргэд, айл өрхийн амьжиргааг дээшлүүлж бүс нутгийн хөгжлийг хангах зорилго бүхий “Төрийн үйлчилгээг шуурхай хэрэгжүүлж, тулгуур төвөө хөгжүүлэе” уриатайгаар боловсруулжээ.

Мөн 2005 онд дотоодын үйлдвэрлэл, хувийн хэвшлийг дэмжих, банк, санхүүгийн салбарын үйлчилгээг өргөжүүлж, бүс нутаг хөдөөгийн хөгжлийг хангах бодлого явуулах замаар эдийн засгийн өсөлт, хүн амын бодит орлогыг нэмэгдүүлэх, ажилгүйдлийг



бууруулахад үндсэн чиглэлийг боловсруулжээ. Үүнд боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлж, багш нарын мэдлэгийг дээшлүүлэн сургуулийн насны хүүхдийн хамран сургалтыг 90,0 хувьд сургуулийн өмнөх насны хүүхдийн хамран сургалтыг 45,0 хувьд хүргэж, 7 настай хүүхэдийг сургуульд хамруулах, хүн амд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж чанарыг сайжруулан урьдчилан сэргийлэх тарилгын хамралтыг 97,0 хувьд хүргэх, хүүхэд, ахмад, эмэгтэйчүүдэд үзүүлэх халамж үйлчилгээг нэмэгдүүлэн амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлого бүхий өрхийн 3 ба түүнээс дээш 0-18 насны хүүхэд бүрт 3000 төгрөг сар бүр олгох, 350 гаруй хүнийг мэргэжил олгох болон давтан сургах, 850 гаруй хүнийг ажлын байртай болгох, Дөргөний УЦС-ын ажлыг үргэлжлүүлэн барьж, Үенчийн УЦС-ыг ашиглалтанд оруулж, Дөргөн-Мянгадын 110 килловат, Булган, Алтай сумын 35 килловаттын цахилгаан дамжуулах шугамыг эхлүүлж, аймгийн ЦТСКомпаний, дулааны “Бадамлах дөл” компанийг хувьчилж, Булган Ярантын 65 км хатуу хучилттай замыг ашиглалтанд өгч, аймгийн төвд 1,5 км хатуу хучилттай авто зам барих, Хөшөөт, Олон булгийн нүүрсний уурхайн нүүрсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, инженерийн хийцтэй 25 худгийг сэргээн засварлах зэрэг асуудлуудыг тусгасан байна.

Илтгэлтэй холбогдуулан 14 хүн үг хэлж хуралдааны 2/4 тогтоолоор “Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай”, 2/5 тогтоолоор “2005 оны үндсэн чиглэл батлах тухай” тогтоолыг тус тус баталсан байна.

“Аймгийн 2005 оны төсвийн төслийн тухай” аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү, эдийн засаг төрийн сангийн хэлтсийн дарга Н.Батаа илтгэлдээ хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 7,3 хувиар буюу 55,6 сая төгрөгөөр давж улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө хангагдаж тайлангийн хугацаанд 7,8 тэрбум төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэнээс 6,4 тэрбум төгрөгийг салбар яамдын харьяа төсөвт байгууллагуудад, 1,4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт байгууллагуудад зарцуулж аймгийн оны эхний 400,5 сая төгрөгийн өр 203,8 сая төгрөг болж буурч байна.

2006 онд орон нутгийн нийт орлогоор 946,6 сая төгрөгийн орлого үүнээс татварын орлогоор 926,6 сая төгрөг, төвлөрсөн төсөвт 602,2 сая төгрөг, орлого төвлөрүүлэхээр, нийт зардлыг 1,5 тэрбум төгрөгөөр сахүүжүүлэхээр төлөвлөсөн тухай илтгэсэн байна.

Хуралдаан илтгэлийг хэлэлцээд 2/6 тоот “Аймгийн 2005 оны төсөв батлах тухай” тогтоолоор аймгийн 2005 оны төсвийн орлогын доод хязгаарыг 946,6 сая төгрөгөөр үүнээс татварын орлогыг 851,6 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1451,7 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 332,7 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 431,0 сая төгрөгөөр баталсан байна.

“Аймгийн аудитын газраас 2004 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2005 оны төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай” аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд илтгэлдээ Тайлангийн

хугацаанд 8 орон тоотой ажиллаж 38 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар 14 тайлан “Зөрчилгүй” стандарт, 22 тайлан “Зөрчилтэй”, 1 тайлан нь “Сөрөг”, 1 тайлан нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” тус тус дүгнэлттэйгээр баталгаажсан байна. Тайлангийн хугацаанд 8 сумын 40 байгууллагад аймгийн төвийн 37 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж 32,6 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлсэнээс 12,8 сая төгрөг нь төлбөр, 19,8 сая төгрөг нь зөрчил байсаныг илтгэлдээ дурдаад 2005 онд орон нутгийн орлогыг 24,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж хөрөнгө оруулалтанд зарцуулах нь зүйтэй гэсэн санал дүгнэлтийг оруулсан байна.

Хуралдаан илтгэлийг хэлэлцээд 2/8 тоот “Тайлан, саналын тухай” тогтоолоор Аймгийн аудитын газар нь Төрийн аудитын, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиуд болон холбогдох стандартуудын хүрээнд чиг үүргээ бүрэн хэгэгжүүлсэн гэж дүгнэжээ.

Тус хуралдаанд аймгийн сонгуулийн хорооны 87, 92 дугаар хэсэг буюу 25, 30 дугаар тойргуудын сонгуулийн талаарх ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцэхээр болж дүгнэлтийг ажлын хэсэгт ажилласан Ардчилсан намын төлөөлөл хэсгийн хороо, сумын хороо, аймгийн хорооны нөхцөл байдал, ажлын хариуцлагагүй шалтгаалсан маргаан тул нэр дэвшигч Д.Мурат, Д.Энхболд нарын төлөөлөгчийн эрхийг баталгаажуулах зүйтэй гэж үзсэнийг ажлын хэсгийн бусад төлөөлөл дэмжээгүй шүүхэр шийдвэрлүүлэх нь зүйтэй гэсэн саналтай байсан тул ажлын хэсгийн шийдвэр хүчин төгөлдөр биш учраас ажлын хэсгийг хангалтгүй ажилласан гэж үзээд асуудлыг хойшлуулж, ажлын хэсгийн гишүүд нэг дүгнэлтэд хүрч асуудлыг шийдвэрлүүлэх зүйтэй гэж хуралдаанаас шийдвэрлэжээ.

Аймгийн ИТХ-ын 2 дугаар хуралдаанд нийт 28 төлөөлөгчийн 25 буюу 89,3 хувь нь хүрэлцэн ирж урилгаар 86 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 80, иргэд 6 байгаа ба хуралдаанд 21 хүн үг хэлж, нийт 5 асуудал хэлэлцэн 8 тогтоол баталсан байна.

### **Ээлжит бус хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 72 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 3 дугаар хуралдааныг 2005 оны 6 дугаар сарын 7-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Газар зохион байгуулалтын 2004 оны тайлан, 2005 онд өмчлүүлэх газрын тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэлийг хэлэлцэхээр товлон зарласан байна.

Хуралдааны нарийн бичгийн даргаар Ж.Цэндаюуш стратегийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн, З.Өмиртэй стратегийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн мэргэжилтэн, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн Ажлын албаны ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна. Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар Г.Нямдаваа, нарийн

бичгийн даргаар Н.Дамба нараар ахлуулсан 7 хүний бүрэлдхүүнтэй ажлын хэсэг ажилласан байна.

Хуралдаан 2004 оны 2 дугаар хуралдаанаар баталсан байнгын дэгийг мөрдөж хуралдсан байна.

Аймгийн газар зохион байгуулалтын явц, цаашид баримтлах бодлого, 2005 онд өмчлүүлэх газрын тухай аймгийн Засаг дарга илтгэлдээ 4 суманд орон тооны газрын даамал ажиллуулж бусад сумдад байгаль орчны асуудал эрхэлсэн ажилтанд газрын харилцааны асуудлыг хариуцуулан Жаргалант суманд 2 хүн ажиллуулж иргэнд газар өмчлүүлэхтэй холбогдуулан аймгийн газрын албанаас сумдын төвийн газрын кадастрын зураглалыг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор гаргаж шинэчлэн гаргасан судалгаагаар аймгийн дүнгээр газар эзэмшигч иргэн 17794, төрийн байгууллага 134, аж ахуйн нэгж 117, өрх 8548, газар өмчлөгч 619 өрхийг бүртгэж төвийн сүлжээнд хамааруулж аймгийн хэмжээнд 619 өрх 145,35 га газрыг өрх бүлийн хэрэгцээнд өмчлүүлэн зохих баримт бүрдүүлсэн 58 иргэнд үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ олгосон байна. Аймгийн нэгдмэл сангийн тайлангаар Ховд аймаг 76,6 мянган га талбайгаа ХАА-н газар 5885 га, хот суурийн газар 28,4 мянган га, зам шугам сүлжээний газар 21,1 мянган га, ойн сав бүхий газар 464,8 мянган га, усан сан бүхий газар 43,1 мянган га, тусгай хэрэгцээний газар 1163,4 мянган га байгаагаас сүүлийн жилүүдэд 609,2 мянган га талбай ямар нэгэн хохирол учирсанаас бэлчээрийн 16477,3 га, газар тариалангийн 1596 га хохирол гарсаныг тэмдэглээд цаашид иргэдэд газар өмчлүүлэх ажил удаашралтай байгааг эрчимжүүлэх, хотын хөгжлийн төлөвлөгөөг баримтлахгүйгээр эмх замбараагүй газар олгож байгааг цэгцлэх, газрын талаархи бүх шатны байгууллагуудын хариуцлагыг өндөржүүлэх шаардлагатай байгааг тэмдэглэсэн байна.

Хуралдаанд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2004 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 199 дугаар тогтоолоор газрын албаны үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөхөөр хурлын тэргүүлэгч Л.Батбаяраар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж газар эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх талаархи сурталчилгаа хангалтгүй байгааг эрчимжүүлэх, газар эзэмшүүлэх, ашиглуулахдаа сонгон шалгаруулалт болон дуудлагын худалдаагаар шалгаруулах, иргэд, аж ахуйн нэгжийн эзэмшил бүхий газарт дахин хэмжилт хийж баталгаажуулан гэрчилгээжүүлэх, газрын татвар хураалтын байдалд аудит хийх, сумдын газрын даамалуудыг ажлын шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг ИТХ-д оруулах, аймгийн газрын албаны удирдлага мэргэжилтэнүүд ур чадвар хангахгүй байгааг тул өөрчлөлт хийх, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Ховд хотын кадастрийн зураг яаралтай хийх зэрэг саналуудыг танилцуулсан байна. Мөн газрын харилцаа геодезийн зураг зүйн газрын кадастрийн албанаас аймгийн газрын албаны ажилтай танилцсан ажлын дүн болон цаашид газрын шинэтгэлийг эрчимжүүлэх талаар хэрэгжүүлэх 18 заалт бүхий саналыг танилцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааны “Газар зохион байгуулалтын цаашдын зорилт, 2005 онд өмчлүүлэх газрын тухай” 2 дугаар тогтоолоор 2005 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээг 3853,9 га, үүнээс гэр бүлийн хэрэгцээнд 1157,5 га, атаршсан газар 484,3 га, аж ахуйн хэрэгцээнд 9,1 га, газар тариаланд 2203,0 га газар төлөвлөн баталсан байна.

Хуралдаанд нийт 28 төлөөлөгчийн 22 нь буюу 78,5 хувь нь ирж урилгаар төсөвт байгууллагын 38 ажилтан оролцож, илтгэлтэй холбогдуулан 10 үг хэлсэн байна.

### **Аймгийн ИТХ-ын 2005 оны 3 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 1 дүгээр сарын 13-ний өдрийн 02 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг 2005 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Жижиг үйлдвэрлэл-үйлчилгээг дэмжин иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх зорилт”-ын тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэлийг хэлэлцэхээр товлон зарласан байна. Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 6 дугаар сарын 6-ний өдрийн 74 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын сонгуулийн 25,30 дугаар тойргийн төлөөлөгчийн асуудлыг сонгуулийн хорооны дарга П.Батаа хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Хуралдаанд аймгийн ИТХ-ын 28 төлөөлөгчөөс 25 төлөөлөгч буюу 89,3 хувь нь, урилгаар 120 хүн оролцсоны 95 нь төсвийн байгууллагын ажилтан, 35 нь иргэн оролцсон байна.

Хуралдааны нарийн бичгийн даргаар Б.Сандагсүрэн аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан, Б.Энхцэцэг аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, Ж.Цэндаюуш аймгийн Засаг даргын тамгын газрын үйлдвэрлэл, дэд бүтэц, байгаль орчин, бодлого зохицуулалтын хэлтсийн ажилтан, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан Т.Аюушжав, Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна. Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн ахлагчаар Г.Нямдаваа, нарийн бичгийн даргаар Н.Дамба нараар ахлуулсан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг ажилласан байна.

Хуралдаан 2004 оны 2 дугаар хуралдаанаар баталсан байнгын дэгийг мөрдөж хуралдсан байна.

Аймгийн Засаг дарга “Жижиг дунд үйлдвэрлэл, бизнесийг дэмжин иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтын тухай” илтгэлдээ ... манай аймгийн нийт өрхийн 45,2-47,2 хувь нь ядуу, 18,2-20,9 хувь нь нэн ядуу өрх тус тус эзэлж, 1419 хүн идэвхитэй ажил эрж, 5864 хүн хөдөлмөр эрхлээгүй бөгөөд ядуу өрхийн эзлэх хувь улсын дундаж 37,5 хувиас 7,0-9,0 хувиар өндөр байгааг тэмдэглэжээ. Илтгэлд энэ үед аж ахуйн үйл ажиллагаа явуулж байгаа компани 170, хоршоо 160, нөхөрлөл 182, салбар 31, төрийн болон орон нутгийн өмчийн газар 10, хувийн жижиг бизнес эрхлэгчид 1564 байгаа ба үүнийг үйл ажиллагааны салбараар ангилбал барилга, барилгын матери алын үйлдвэрлэлийн 15, бөөний болон

жижиглэн худалдааны 360,0, боловсруулах үйлдвэрлэлийн 88, зочид буудал, зоогийн газрын 68, тээвэр холбооны 38, уул уурхайн олборлох үйлдвэрлэлийн 6, ХАА, ан агнуур ойн аж ахуйн 127, цахилгаан эрчим хүч, дулааны 8, санхүү, үл хөдлөх хөрөнгө, түрээс, бизнесийн чиглэлийн 66, эмнэлэг, нийгмийн үйлчилгээний 106 аж ахуйн нэгж ажиллаж байна.

Дээрхи байгууллагууд жилд 8,3 тэрбум төгрөгийн борлуулалт хийж ажилгүйдлийг бууруулж иргэдийн хэрэгцээг хангах талаар ажиллаж байгааг тэмдэглэн цаашид улам эрчимтэй хөгжүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд: Гадаад харилцаанд бизнес эрхлэгчдийн оролцоог нэмэгдүүлэн техник технологийн шинэчилэлийн гадаад харилцаа тогтооход дэмжлэг үзүүлэх, аймгийн тэргүүлэх чиглэлийн үйлдвэрлэл үйлчилгээ, бизнесийн чиглэлийг тогтоон жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх дэд хөтөлбөр баталж мөрдөх, банк санхүүгийн дэмжлэгийг тогтвортой нэмэгдүүлэх, мэргэжлийн ажилтан бэлтгэх, давтан сургах сургалтыг бий болгох, бизнесийн таатай орчинг бүрдүүлэн элдэв хүнд суртал, дарамт шахалтыг халах, мэдээлэлийн зөв орчинг бүрдүүлэн Ховдын брэнд бүтээгдхүүнийг бий болгох зэрэг үйл ажиллагааг дэмжих зэрэг зорилтуудыг дэвшүүлэн “Жижиг дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдийг дэмжиж иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх зорилтын тухай” 3/2 тоот тогтоолыг баталжээ.

Мөн хуралдаанд аймгийн сонгуулийн хорооны дарга П.Батаа аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 25, 30 дугаар тойргийн санал хураалтын тухай танилцуулгыг төлөөлөгчдөд танилцуулсан байна.

Танилцуулгад аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 25, 30 дугаар тойрог буюу Жаргалант сумын сонгуулийн 87, 92 дугаар хэсгийн хороонд санал хураалтын маргааны улмаас Жаргалант сумын сонгуулийн салбар хорооноос санал хураалтыг хүчингүй болгосон ба дахин сонгууль явуулахад Эх орон ардчилал эвсэлээс сумын сонгуулийн хороонд ажилласан ажилтануудаа татсан учир шийдвэр хэрэгжүүлэх боломжгүй болсон ба цаашид захиргааны хэргийн шүүхээр асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй гэж мэдээлсэн байна.

Дээрх саналаар төлөөлөгчдийн санал хурааж нийт 11 төлөөлөгч буюу олонх нь маргаантай 2 тойргийн асуудлыг аймгийн ИТХ-аас аймгийн зохих шатны шүүхэд өгч шийдвэрлүүлэх нь зүйтэй гэж шийдвэрлэсэн байна.

Хуралдаанд аймгийн Ардчилсан нам, Эх орон нам, Иргэний зориг намаас мэдэгдэл ирүүлсэн байна. Мэдэгдэлд аймгийн ИТХ байгуулагдаж, Засаг дарга томилогдон 8 сарын хугацаа өнгөрч байгаа ч аймгийн нийгэм эдийн засагт дорвитой өөрчлөлт хийгээгүй, намын харьяалалаар боловсон хүчний томилгооны бодлогыг хэрэгжүүлсэн, бараа бүтээгдхүүний үнэ байнга нэмэгдэж ард иргэдийн амьдралд хүндрэл учирч буй, 25,30 дугаар тойргийн төлөөлөгчийн асуудлыг шийдээгүйгээс Жаргалант сумын Буянт, Рашаант багийн сонгогчид төлөөлөлгүй хохирч байгааг буруушаагаад дараах шаардлагыг тавьсан байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ-ын 25, 30 дугаар тойрогт олонхийн санал авсан Д.Энхболд, Д.Мурат нарын бүрэн эрхийг зөвшөөрөх

2. Төрийн албаны боловсон хүчнийг намын харьяалал харгалзахгүйгээр шударгаар өрсөлдүүлж томилох, аймгийн ИТХ-ын хуралдаанаас тогтоол гаргах

3. 2000-2004 оны аймгийн санхүүгийн болон газар эзэмшүүлэх үйл ажиллагаанд намуудын оролцоотой иж бүрэн шалгалт хийх ажлын хэсгийн хуралдаанаас тогтоолоор байгуулах ба дээрхи санал санаачилгыг хэрэгжүүлээгүй тохиолдолд аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргыг огцруулах асуудлыг хуулийн дагуу хуралдаанаар хэлэлцэх шаардлагыг тавьсан байна.

Хуралдаанд илтгэлтэй холбогдуулан 11 хүн асуулт асууж, 13 хүн үг хэлж танилцуулгатай холбогдуулан 8 хүн асуулт асууж 9 хүн саналаа хэлсэн байна.

#### **Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн 151 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдааныг 2007 оны 12 дугаар сарын 22-23-ний өдөр хуралдуулж

1.Аймгийн ИТХ-ын тайлан, НӨУЁБ-ын үйл ажиллагааг өөрчлөн сайжруулах зорилтын тухай,

2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2005 оны үндсэн чиглэлийн биелэлт,2006 оны үндсэн чиглэл, ажилгүйдэл, ядууралыг бууруулах хөтөлбөрийн зорилтын тухай илтгэл

3. Аймгийн 2006 оны төсвийн төсөл орон нутгийн түгээмэл тархацтай байгалийн баялаг ашигласаны татварын хувь хэмжээг тогтоох тухай илтгэл

4. Аудитын газрын 2005 оны тайлан, 2006 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл

5. Газар зохион байгуулалтын 2005 оны урьдчилсан дүн, 2006 онд өмчлүүлэх газрын тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна. Дээрхи илтгэлүүдийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2005 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж 162 дугаар тогтоолоор илтгэлүүдийг зөвшөөрч хуралдаанд оруулах тухай шийдвэрлэсэн байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн 3.7-д “... зохион байгуулалтын асуудлыг эхэнд нь хэлэлцүүлнэ” гэснийг энэ удаагийн хуралдаанд мөрдөхгүй байхаар тогтоож дэгийн бусад заалтыг мөрдөхөөр хуралдаж ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, Ж.Цэндаюуш Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга, аймгийн аудитын газрын ахлах шинжээч Б.Түмээ, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл Б.Шоовдой, Т.Аюушжав Засаг даргын тамгын

газрын ажилтан, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн Засаг дарга Г.Нямдаваагаар ахлуулан 10 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Хуралдааны эхэнд аймгийн ИТХ дах Эх орон-Ардчилсан эвслийн бүлгийн ахлагч Ц.Бямбаа зуурдаар нас барсан тул цөөнхийн бүлгийн ахлагчаар төлөөлөгч Б.Батсүхийг сонгож ажиллуулах болсныг мэдэгдсэн байна.

Мөн аймгийн ИТХ-ын цөөнхийн бүлгээс аймгийн Засаг дарга болон Засаг даргын Тамгын газраас төрийн ажлыг улс төржүүлсэн, ажлаа Улаанбаатар хотоос удирдаж буй, 2005-2006 оны өвөлжилтийн бэлтгэл ажил хангах асуудалд туйлын хангалтгүй хандсан, 2006 оны төсвийг үндэслэл муутай боловсруулсан, аймаг түүний дотор Жаргалант суманд газар зохион байгуулалтын бодлого алдагдсан, Засаг дарга Г.Нямдаваа нам эвсэлийн зөвшилцөлийг хэрэгжүүлээгүй, албан газар байгууллагуудад удирдах удирдуулах зарчим алдагдсан, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, төрийн сангийн хэлтсийн дарга нар тэргүүлэгчээр ажилладаг нь нутгийн өөрөө удирдах ёсын мөн чанарыг алдагдуулсан тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга О.Ширэндэв, Засаг дарга Г.Нямдаваа нарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг хурлаар хэлэлцэх, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Л.Батбаяр, төрийн сангийн хэлтсийн дарга Н.Батаа нарыг Тэргүүлэгчээс чөлөөлөх тухай мэдэгдэл хийсэн ба үүнийг хуралдааны төгсгөлд зохион байгуулалтын асуудлын хамт хэлэлцэхээр тогтсон байна.

Аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв илтгэлдээ Аймгийн ИТХ Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Засгийн Газрын 90 дүгээр тогтоол, Монголын Нутгийн Удирдлагын Холбооны III их хурлын шийдвэрийг удирдлага болгон Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчимд тулгуурлан нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зах зээлийн хүрээ өргөтгөх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх замаар ард иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын нийгмийн хамгааллыг өргөтгөх, санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг аймгийн хэмжээнд тулгарсан асуудлуудыг судлан шийдвэрлэхэд өөрийн нөөц боломж, онцлогийг харгалзан бодлого, чиглэлээ тодорхойлохоор аймгийн ИТХ-ын III болон ээлжит бус хуралдааныг төлөөлөгчдийн 78,5-89,3 хувийн ирцтэйгээр хийсэн тухай тэмдэглэжээ.

ИТХ-ын хуралдааны чөлөөт цагт тэргүүлэгчид 31 удаа хуралдуулж 178 асуудал хэлэлцүүлэн 161 тогтоол, 2 хөтөлбөр, 10 гаруй журам баталсан байна. Тэргүүлэгчдийн

хуралдаанаар багийн И НХ-ын хуралдааны үргэлчилсэн дэг, аймгийн ИТХ-ын Төлөөлөгчдийн өдөр зохион байгуулах, тэргүүний багийн ИНХ болон “Жишиг баг” шалгаруулах журам, ИТХ-ын байнгын хэсгийн дүрэм, санхүү, төсөв, өмч, байгаль экологи, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд, спорт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын удирдах арга барилыг сайжруулах, НААҮ, дулаан, цахилгаан, холбоо мэдээлэл, авто зам засвар зэрэг дэд бүтцийг өргөтгөх зэрэг ажил хэрэгч асуудлаар удирдлагуудын илтгэл, мэдээлэл хэлэлцсэн байна

Аймгийн хэмжээгээр 2005 онд боловсрол соёл, эрүүл мэндийн салбарт 300,0 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 91,1 сая төгрөг, бусад хөрөнгө оруулалтаар 5,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна.

Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нэмэгдэж Дөргөний УЦС, Булган – Алтай сумын босоо тэнхлэгийн зам барих, Үенчийн УЦСтанцын бүтээн байгуулалтаас гадна Дарви сумын соёлын төв, 50 хүүхдийн цэцэрлэг, Эрдэнэбүрэн, Манхан, Дөргөн сумын соёлын төв зэрэг байгууламжийн засвар үйлчилгээг хийсэн байна.

Тус онд аймаг 1905,2 мянган мянган мал тоолуулж 20 худаг сэргээн засварлаж, 2255,7 га-д тариалалт хийж 18,2 мянган тн ургац хураан авчээ.

2005 оны төсвийн орлогын бүрдүүлэлт 786,7 сая төгрөгт зарлага 8,6 тэрбум төгрөгт хүрч аймаг 17,2 тэрбум төгрөгийн өмчтэй болсоныг тэмдэглэжээ.

Тайлангийн жилд Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулахад арга зүйн туслалцаа үзүүлж төрийн дээд шагналаар шагнуулахаар 44 хүний тодорхойлолтыг өргөн мэдүүлж Гавьяат малчин-1, хүний гавьяат эмч-1, хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон-1, алтан гадас одон-9, хөдөлмөрийн хүндэт медаль-10, шударга журам медаль 1 иргэн хүртэж алдарт эх I,II дугаар одонгоор нийт 122 эх шагнагдсан байна. Аймгийн ИТХ-аас цаашид Хурлын байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн шинэчлэх, нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогоо зөв тодорхойлох, биелэлтийг зохион байгуулах, практик үйл ажиллагаа болгох, үр дүнг тооцож сурталчлах бүх шатанд өөрчлөн сайжруулах зорилтыг дэвшүүлсэнийг илтгэлдээ тусгасан байна.

“Үйл ажиллагааны хөтөлбөрийн болон эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2005 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2006 оны үндсэн чиглэл, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах тухай” аймгийн Засаг дарга Г.Нямдаваа итгэлдээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 244 зорилтыг хэрэгжүүлэх 344 заалт бүхий төлөвлөгөөний энэ онд тусгагдсан 35 заалтын 19 нь бүрэн хэрэгжиж, 2 нь 90,0 хувь, 5 нь 70,0 хувь, зургаа нь 50,0 хувь, гурав нь 10,0 хувьтай биелүүлсэнийг тэмдэглэсэн байна

Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргын илтгэлийг хэлэлцээд “Ажилгүйдэл, ядуурлыг бууруулах жил” болгох тухай тогтоолыг баталсан ба тогтоолд аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс удирдлагын арга барилыг өөрчлөн, нутгийн удирдлагын чадавхийг бэхжүүлэн, үйл ажиллагааг нь сайжруулж, сумын ИТХ, захиргааны байгууллагуудад мэргэжил



арга зүйн туслалцаа үзүүлэн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх талаар 2005 онд ахиц өөрчлөлт гаргасан байна гэж үзсэн бөгөөд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 32,1 хувь хэрэгжсэн байна гэж дүгнэсэн байна.

“2006 оны орон нутгийн төсвийн төсөл, түгээмэл тархацтай ердийн ашигт малтмалыг ашигласаны төлбөрийг өөрчлөн тогтоох тухай Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 0,7 хувиар давж улсын төсөвт төвлөрүүлэх орлого 1,3 хувиар тасрахаар, тайлангийн хугацаанд 8,6 тэрбум төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэн

2006 онд орон нутгийн нийт орлогоор 1,2 тэрбум төгрөгийн орлого үүнээс татварын орлогоор 464,6 сая төгрөг, нийт зардлыг 1,5 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн тухай илтгэсэн байна.

Тус илтгэлтэй холбогдуулан төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хэсгээс зөвхөн орон нутгийн төсвийг баталж байгаа нь төвлөрөлийг сааруулах биш гааруулсан, зах зээлд бараа, шатахууны үнэ нэмэгдэж байхад төсвөө нэмэхгүй байгаа нь хөгжлийг сааруулж байна, үүнээс төсвийн хууль зөрчигддөг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг сумдын төсөвт төсөвлөх, салбарын яамдуудтай байгуулах гэрээнд аймгийн хөгжлийн хөрөнгө оруулалтын асуудлыг бүрэн тусгах, санхүүгийн сахилгыг сайжруулан өмч хөрөнгөнд тавих хяналт, төсвийн зардлын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байгаа тухай дүгнэсэн байна.

Илтгэлийг хэлэлцээд аймгийн 2006 оны төсвийн орлогын доод хязгаарыг 1530,2 сая төгрөгөөр үүнээс татварын орлогыг 1042,3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1530,2 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 364,5 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 506,8 сая төгрөгөөр тус тус 8/3 дугаар тогтоолоор баталсан байна. Мөн 8/4 дүгээр тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2006 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийн 7626,7 сая төгрөгийг тус тус сайшаан дэмжсэн байна.

Мөн 4/6 тоот тогтоолоор “түгээмэл тархацтай ердийн ашигт малтмал /элс, хайрга, тоосгоны болон шар шавар, барилгын чулуу, шохойн чулуу, боржин чулуу, зос будгийн түүхий эд, хужир, шүү, давс/-ын ашиглалтын төлбөрийн хэмжээ тогтоож 2006 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлэхээр шийдвэрлэжээ.

Аймгийн аудитын газраас 2005 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2006 оны төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд илтгэлдээ 168 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар мөнгөн хөрөнгийг 1,2 сая төгрөг, үндсэн хөрөнгийг 3,5 сая төгрөг, засгийн газрын санг 3,6 сая төгрөгөөр илүү, бараа материалыг 0,3

сая төгрөг, өглөгийг 18,8 сая төгрөгөөр тус тус дутуу илэрхийлсэн алдаа илэрүүлэн 119 тайлан “Зөрчилгүй” стандарт, 53 тайлан “Зөрчилтэй”, 2 тайлан нь “Сөрөг”, 5 тайлан нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” тус тус дүгнэлт өгсөн байна. Тайлангийн хугацаанд 8 сум 40 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж 181,1 сая төгрөгийн зөрчил төлбөр илрүүлсэнээс 51,4 хувь нь төлбөр, 48,6 хувь нь зөрчил байсаныг тайландаа дурдаад 2006 онд орон нутгийн орлогыг 32,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн эрүүл орчинг бүрдүүлж хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлсэнээр төсвийн хэтрэлт гаргахгүй ажиллах бололцоотой байна гэсэн санал дүгнэлтийг оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан төсвийн зарлага санхүүжилтийн хяналтын хэсгээс аудитын байгууллага дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлж төрийн аудитын чиг үүргээ хуулийн хүрээнд биелүүлж ажиллаж байгаа бөгөөд 2006 оны орлого нэмэгдүүлэх болон зардлыг бууруулах саналыг дэмжиж цаашид бүх шатны удирдлага холбоо, суудлын автомашины зардлыг хэтрүүлэн хувийн ажилд ашиглаж буйг таслан зогсоож лимит тогтоож мөрдөх, татварын байгууллага далд бизнесийг татварт хамааруулах талаар хангалтгүй ажиллаж байгааг өөрчлөх, зээл тусламжийн ашиглалт туйлын хангалтгүй, өмч хөрөнгөд тавих хяналт сул, тендерийн ажиллагаа будилантайгаас гүйцэтгэсэн ажлын чанар хангалтгүй, банкны байгууллагуудын зээлийн ажиллагаа хяналтгүйгээс ард иргэдэд дарамт болж байгаа, төсөв захирагчдын үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас зарлагаа хэтрүүлдэг санхүүгийн сахилга байнга зөрчигдөж байгаад дүгнэлт хийж зохих арга хэмжээ авч хэрэгжүүлэн үр дүнг хуралдаанд илтгэж байхыг анхааруулсан дүгнэлт гаргасан байна.

Илтгэлийг хэлэлцээд 4/8 тоот тогтоолоор аймгийн аудитын газрыг 2005 онд аймагт нийлүүлэх бүтээгдхүүн, ажил үйлчилгээний гэрээгээ бүрэн биелүүлж Төрийн аудитын, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиуд болон холбогдох стандарт журмуудын хүрээнд үйл ажиллагаа идэвхитэй явуулсан байна гэж дүгнэжээ.

Газар зохон байгуулалтын 2005 оны дүн, 2006 онд өмчлүүлэх газрын тухай аймгийн газрын албаны дарга Ч.Баатаржав илтгэлдээ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийлгэх хөрөнгө шийдвэрлэгдэж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан ажлаа эхэлсэн ба 3689 иргэн 683,41га газрыг гэр бүлийн хэрэгцээнд өмчлөн төлөвлөгөөний биелэлт 62,5 хувьд хүрсэн, тус онд өмчлүүлэхээр тогтоосон 3808,46 га газраас 683,41 га газар өмчлөгдөж 3259,68 га газар зориулалтаараа үлдээд байгаа ба 2006 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ 3364,08 га, үүнээс гэр бүлийн хэрэгцээнд 667,72 га, аж ахуйн хэрэгцээнд 11,1 га, тариалангийн талбайд 2200,96 га, атаржсан газраас 484,3 га газар өмчлөгдөх боломжтой байна гэж үзээд төлөвлөгөөнд тусгуулах санал оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан хөдөөгийн бодлого байгаль орчны бодлогын хэсгээс 2005 онд төлөвлөгдсөн газар өмчлүүлэх дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулах асуудал тасарсан, иргэдэд газар өмчлүүлэх ажил удаашралтай, түүнийг зохион байгуулан

хэрэгжүүлэх талаар санаачилга муутай ажилласан, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг яаралтай нарийвчлан хийлгэж аймгийн ИТХ—д танилцуулан батлуулахыг дүгнэлт санал болгосон байна.

Илтгэлийг хэлэлцээд газар зохион байгуулалтын 2006 онд иргэнд өмчлүүлэх газрыг 2879,78 га, үүнээс гэр бүлийн хэрэгцээнд 667,72 га, аж ахуйн хэрэгцээнд 11,1 га, тариалангийн талбайд 3200,96 га байхаар 4/9 дүгээр тогтоолоор баталжээ.

Цөөнхийн бүлгээс хийсэн мэдэгдэлийн заалт бүрээр холбогдох албан тушаалтанууд зохих ёсны тайлбар хийсний дараа МАХН-ын бүлгээс аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт илтгэл үзүүлэх эсэх, 2 тэргүүлэгчийг өөрчлөх тухай асуудлыг татаж авахыг санал болгосон боловч цөөнхийн бүлгээс завсарлага авч татаж авах боломжгүй байгаа тухай мэдэгдсэн байна.

Иймээс МАХН-ын бүлгээс мэдэгдэл хийж цөнхийн бүлгийн мэдэгдлийг анхааралтай судалж үзэхэд иргэд сонгогчдын эрх ашиг гэхээсээ илүү улс төрийн байр сууриа илэрхийлж байгаа тул үүнийг хүлээж авах боломжгүй байгааг мэдэгдээд аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарын илтгэлийг хэлэлцээд ажлыг хангалттай гэж дүгнэсэн, Тэргүүлэгч Л.Батбаяр, Н.Батаа нар үндсэн хуулинд заасан сонгогдох, сонгох эрхээ эдлэх учиртай тул үүнийг хэлэлцэх шаардлагагүй бөгөөд цөөнхийн бүлгээс дээрхи саналаа татаж авахыг шаардсан байна.

Мөн цөөнхийн бүлгээс аймгийн ИТХ-ын 25,30 дугаар тойргийн төлөөлөгчдийн асуудлаар асуулт асууж аймгийн Захиргааны хэргийн шүүхээс 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр 11.а, 12.а дугаартай тогтоолоор Жаргалант сумын сонгуулийн хорооноос санал хураалтыг хүчингүй болгосон тогтоолыг илт хүчин төгөлдөр бус гэж шийдвэрлэснийг хуралдаанд уншиж танилцуулсан байна.

Аймгийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт илтгэл үзүүлэх эсэх, 2 Тэргүүлэгчийг татах асуудлыг хэлэлцүүлэхээр санал оруулахад төлөөлөгчдийн олонхийн саналаар шаардлагагүй гэж үзэж олонхийн шийдвэрийг хүлээн авсан байна.

Цөөнхийн бүлгээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид нэр дэвшүүлсэн төлөөлөгч Б.Батсүхийг 100 хувийн саналаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр нөхөн сонгосон байна.

Аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанд нийт 29 төлөөлөгчийн 22 буюу 76,0 хувь нь оролцож урилгаар 126 хүн оролцоноос төсвийн байгууллагын ажилтан 76, иргэд 50 байгаа ба хуралдаанд 27 хүн үг хэлж, нийт 5 асуудал хэлэлцэн 9 тогтоол баталсан байна.

### **Ээлжит бус хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 5 дугаар сарын 30-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор ээлжит бус хуралдааныг 2006 оны 6 дугаар сарын 9-ний өдөр хуралдуулахаар зарлаж аймгийн ИТХ-ын 25, 30 тойргийн төлөөлөгчийн бүрэн эрх зөвшөөрөх тухай, мөн 14 дүгээр тойргийн нөхөн сонгуулийн дүнг хэлэлцэж төлөөлөгчийн бүрэн эрх зөвшөөрөх тухай

асуудлыг хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 6 дугаар сарын 8-ний өдрийн хуралдаанаар ажлын зайлшгүй шаардлагаар “ээлжит бус хуралдааны хугацааг хойшлуулах тухай” 124 дүгээр тогтоол гаргаж хуралдааныг 2006 оны 6 дугаар сарын 12-ний өдөр хуралдуулахаар зарлаж өмнө зарласан 2 асуудал дээр аймгийн 2006 оны төсвийн тодотголын тухай нэмж хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна.

Ээлжит бус хуралдаанд ирвэл зохих 27 төлөөлөгчийн 23 буюу 85,2 хувь ирсэн тул аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв үг хэлж нээж хуралдааны ажиллагаа эхлэхэд аймгийн ИТХ дахь цөөнхийн бүлгээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга Д.Ширэндэв хуулиар олгосон эрхийн хэмжээнд аймгийн Засаг дарга болон Тэргүүлэгчдийг удирдлагаар хангаж ажиллаагүй нийт 160 хоногийн 60 хоногт нь өвчтэй чөлөөтэй нэрээр ажиллаагүй бөгөөд Тэргүүлэгчдийн хуралдааны 50 хувьд оролцоогүй аймгийн ИТХ-ын 25,30 дугаар тойргийн маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар санаачилга гаргаагүй тул түүнд илтгэл үзүүлэх эсэх талаар хуралдаанаар хэлэлцэхийг шаардсан мэдэгдэл хийсэн байна.

Уг асуудлыг хэлэлцэх асуудлаар санал зөрөлдсөнөөс МАХН-ын бүлэг завсарлага авч хуралдаж нууц санал хураалтаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн байна. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга О.Ширэндэвт итгэл үзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэх эсэх талаар нууц санал хураалтаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзээд Х.Дарьгерхан даргатай тооллогын комисс байгуулж нууц санал хураахад нийт 24 төлөөлөгчөөс 13 буюу 55,1 хувь нь итгэл үзүүлэх эсэх асуудлыг хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн байна.

Ээлжит бус хуралдааны 01 тоот тогтоолоор хуралдааны дэг, хэлэлцэх асуудал, дотоод журмыг баталсан байна.

Ээлжит бус хуралдааны хуралдаанд үйлчлэх албаны бүрэлдхүүнд нарийн бичгийн даргаар аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан М.Отгонханд санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ш.Ичинхорлоо төрийн захиргааны хэлтсийн түшмэл, Л.Оюунцэцэг Хуулийн хэлтсийн түшмэл, редакцийн комиссоор Ч.Цэрэнчимэд аймгийн ерөнхий аудитор, Б.Шоовдой төрийн захиргааны хэлтсийн түшмэл, тэмдэглэл хөтлөгчөөр Б.Энхтуяа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан нар ажилласан байна.

Хуралдаанд аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 25,30 дугаар тойрогт нэр дэвшиж сонгогдсон аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн бүрэн эрхийн тухай мэдээлэлийг аймгийн сонгуулийн хорооны дарга П.Батаа хийсэн ба мэдээлэлдээ аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох 25,30 дугаар тойрогийн маргаантай асуудлыг шийдвэрлэх талаар хэрэгжүүлж байсан ажлуудыг өмнөх хурлуудад мэдэгдэж байсан ба Ховд аймгийн захиргааны хэргийн шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн тухай аймгийн ерөнхий шүүгчийн 2006 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 85 тоот албан бичгийг ирүүлсэн бөгөөд Жаргалант сумын сонгуулийн хороо 56,0 хувийн ирцтэйгээр хуралдаж Д.Энхболд, Д.Мурат нарын аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн

эрхийг зөвшөөрөх санал оруулах шийдвэр гаргасан тул аймгийн сонгуулийн хорооноос Жаргалант сумын сонгуулийн 87 болон 92 дугаар хорооны 2004 оны 10 дугаар сарын 17-ний өдрийн тогтоолыг үндэслэн 25 дугаар тойрогт 46, 97 хувийн санал авсан Д.Энхболд, 30 дугаар тойрогт 50, 39 хувийн санал авсан Д.Мурат нарыг төлөөлөгчөөр сонгогдсон шийдвэр гаргаж бүрэн эрхийг зөвшөөрүүлэхээр өргөн барьсаныг мэдээлсэн байна.

Мөн аймгийн сонгуулийн хорооны дарга Н.Дамба аймгийн ИТХ-ын 14 дүгээр тойргийн нөхөн сонгуулийн дүн, аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхийн тухай илтгэлдээ аймгийн ИТХ-ын 14 дүгээр тойргийн нөхөн сонгуулийг 2006 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн Ням гаригт явуулахаар зарлаж 6 хэсэг байгуулан нийт 52 хүн ажиллаж, МАХН, Ардчилсан намаас тус бүр нэг хүн нэр дэвшиж 2085 сонгогчийн 89,4 хувь нь сонгуульд саналаа өгч, МАХН-аас нэр дэвшигч П.Эрвээхэйн төлөө 66,9 хувь нь саналаа өгсөн тул аймгийн ИТХ-ын төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрүүлэхээр өргөн барьсаныг илтгэсэн байна.

Хуралдаан төлөөлөгчийн бүрэн эрхийг зөвшөөрөх тухай 02 дугаар тогтоолоор төлөөлөгчдийн 100 хувийн саналаар аймгийн ИТХ-ын төлөөлөгч Д.Энхболд, Д.Мурат, П.Эрвээхэй нарын бүрэн эрхийг зөвшөөрсөн байна.

Хуралдаан орон нутгийн 2006 оны төсөвт төрийн албан хаагчийн цалинг 30,0 хувиар нэмсэн албан томилолтын зардал өөрчлөгдөн нэмэгдсэн, нийгмийн халамж үйлчилгээний чиглэлийн арга хэмжээг шинээр авсан зэргээс шалтгаалан тодотгол хийж орлогыг 35,8 сая төгрөгөөр нэмэгдүүлж зарлагыг 194,6 сая төгрөгөөр нэмэгдүүлэх тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэлийг хэлэлцэж хуралдааны “Орон нутгийн 2006 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай” 3 дугаар тогтоолоор аймгийн ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар баталсан орлогыг 35,9 сая төгрөгөөр, зарлагыг 194,6 сая төгрөгөөр нэмэгдүүлж сумдын орлогын доод хязгаарыг 19,4 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 101,1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталж орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын 2006 оны төсвийг 925,9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэнийг сайшаасан байна.

Хуралдаанд аймгийн АН-ын дарга Б.Баярсайхан “Ардын намын шинэтгэл Ховд аймаг” хэлэлцүүлэгийн үеэр иргэдээс гаргасан саналаас буюу ядуурал газар авч үнийн өсөлт ядуугийн дарамт болж байгаа тухай, хөдөлмөрийн насны 54,0 мянган хүний 4,1 хувь нь хөдөлмөр эрхлээгүй буруу статистик байгаа тухай, зээл тусламж хувиарлах, газар өмчлүүлэх, ашиглахад зөвшөөрөл олгоход авилгал их байгаа тухай, элдэв төрлийн зөвшөөрөл лицензээр төрийн алба хүнд сурталтай байгаа, төрийн албаны сонгон шалгаруулалтыг будлиантуулан улс төржүүлдэг тухай үг хэлж мэдэгдсэн байна.

Хуралдаанд 27 төлөөлөгчийн 85,2 хувь нь, урилгаар 25 хүн үүнээс төсөвт байгууллагын ажилтан 25 хүн оролцож 2 асуудал хэлэлцэн 3 тогтоол гаргасан байна.

## **Аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2006 оны 11 дүгээр сарын 28-ний өдрийн 275 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдааныг 2006 оны 12 дугаар сарын 22-ний өдөр хуралдуулж

1. Аймгийн ИТХ-ын тайлан, НӨУЁБ-ын үйл ажиллагааг идэвхжүүлэх тухай илтгэл
2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, ажилгүйдэл, ядууралыг бууруулах жилийн ажлын дүн, цаашдын зорилтын тухай илтгэл
3. Аймгийн эдийн засаг, нийгмийг 2006 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2007 оны үндсэн чиглэл, төсвийн төслийн тухай илтгэл
4. Аудитын 2006 оны тайлан, 2007 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл
5. Иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2007 оны төлөвлөгөөний тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Дээрхи илтгэлүүдийг аймгийн ИТХ-ын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж 295 дугаар тогтоолоор илтгэлүүдийг зөвшөөрч хуралдаанд оруулах тухай шийдвэрлэсэн байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгийн 3.7-д “... зохион байгуулалтын асуудлыг эхэнд нь хэлэлцүүлнэ” гэснийг энэ удаагийн хуралдаанд өөрчилж “зохион байгуулалтын асуудлыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн санал болгосоны дагуу хэлэлцэх асуудлын дараалалд оруулсанаар хэлэлцэж шийдвэрлэнэ” гэж өөрчилж дэгийн бусад заалтыг хэвээрээ мөрдөхөөр хуралдаж ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл, Ш.Ичинхорлоо, Б.Нарантуяа нийгмийн бодлогын хэлтсийн түшмэл, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл Б.Шоовдой, Б.Базар Зэрэг сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн ажлын хэсгийг аймгийн Засаг дарга Г.Нямдаваагаар ахлуулан 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга О.Ширэндэв илтгэлдээ: Аймгийн ИТХ Төрийн хууль тогтоол, Засгийн газрын болон өөрөөсөө гарсан бодлого шийдвэрийг сурталчилж биелүүлэх ажлыг Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хүрээнд хамаарагдаж байгаа бүх шатны сонгуультай, хариуцлагатны хүчин чармайлтаар орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төсөв, санхүүг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг тулгамдсан

асуудлуудыг судлан шийдвэрлэхэд өөрийн нөөц боломж, онцлогийг харгалзан бодлого, чиглэлээ тодорхойлохоор аймгийн ИТХ-ын ээлжит бус хуралдааныг төлөөлөгчдийн 85,2 хувийн ирцтэйгээр хуралдуулан, тэргүүлэгчид 37 удаа хуралдуулж 311 асуудал хэлэлцүүлэн 285 тогтоол гаргаж санхүүгийн сахилгыг сайжруулах, сумдын ИТХ, багийн ИНХ-ын шинэлэг арга барилаас суралцах, аймгийн өмчийн 2005 оны дүнгийн тухай, хог хаягдлын менежментийг сайжруулах тухай, Их Монгол улс байгуулагдсаны 800 жилийн ойн угтсан ажлыг эрчимжүүлэх тухай, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, өөрийгөө санхүүжүүлэх чадварыг дээшлүүлэх тухай, нийгмийн эрүүл мэндийн талаар авах зарим арга хэмжээний тухай, халдварт өвчнөөс сэргийлэх хянах, тухай, малын хулгайтай тэмцэх хөтөлбөр, барилга хот байгуулалтын албаны дүрэм, зэрэг санхүү, төсөв, өмч, байгаль экологи, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд, спорт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын удирдах арга барилыг сайжруулах, дулаан, цахилгаан, холбоо мэдээлэл, авто зам засвар зэрэг дэд бүтцийг өргөтгөх зэрэг асуудлаар удирдлагуудын илтгэл, мэдээлэл хэлэлцэж зохих шийдвэр гаргасан байна.

Аймгийн хэмжээний 91 багийг ажлын дэвтэртэй болгож, багийн ИНХ-ын байнгын үлгэрчилсэн дэгийг баталж мөрдүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын сонгуулийн эрхийн хугацааны үйл ажиллагааны үндсэн чиглэлийн 147 заалтын 62,58 хувийг биелүүлж ИТХ, Тэргүүлэгчдийн 282 тогтоолын биелэлт 90,0 хувь, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 61,2 хувьтай байгааг тэмдэглэсэн байна.

Эдийн засаг нийгмийн хөгжлийн хувьд анх удаа аймаг 2,3 сая мал тоолуулж 2507 га-д тариалалт хийж 20,5 мянган тн ургац хурааж бүтээн байгуулалтанд 7,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, Дөргөний УЦС-ын объектийн ажил эрчимжиж, Үенчийн УЦС, Үенч Булган болон Мянгад Дөргөний ЦДАШугам, Жаргалант суманд 960 хүүхдийн сургуулийг ашиглалтанд оруулж, 1051 метр асфальтон бетон зам, 360,0 сая төгрөгийн их засварын ажил хийж 2006 оны орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт 716,8 сая төгрөгт зарлага 1,9 тэрбум төгрөгт хүрч, аймаг 17,5 тэрбум төгрөгийн өмчтэй болсоныг тэмдэглэжээ.

Тайлангийн жилд аймгийн ИТХ-ын 14 дүгээр тойрогт нөхөн сонгуулийг зохион байгуулж сонгогчдын 89,4 хувь нь оролцсон, сумдын ИТХ-ын 10 тойрогт нөхөн сонгууль явуулахад арга зүйн туслалцаа үзүүлсэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн ажлыг удирдлага зохион байгуулалтыг хангаж ажилласан гэмт хэргийн тоо 452-д хүрч 30,1 хувиар өссөн, цагаатгалын ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссын төлөвлөсөн ажил хэрэгжсэн, төрийн дээд шагналаар шагнуулахаар 146 хүний тодорхойлолтыг өргөн мэдүүлж Гавьяат эдийн засагч, эмч, багш, соёлын гавьяат зүтгэлтэн төрж, алтан гадас одонгоор -23, хөдөлмөрийн хүндэт медалиар -18, шударга журам медаль 1 иргэн хүртэж, алдарт эх I, II дугаар одонгоор нийт 145 эх шагнагдсан тухай тусгасан байна. Аймгийн ИТХ-аас цаашдын зорилтыг 2007 оныг бүтээн байгуулалтын жил болгож Дөргөний

УЦС-ыг 11,12 дугаар саруудад ашиглалтанд оруулах, мянганы босоо тэнхлэгийн замыг барих бэлтгэл ажлыг эртнээс хангаж ажиллах, хөшөөтийн уурхайн төслийг эхлүүлэх, Ховд хотод 2 км хатуу хуучилттай зам тавьж ногоон байгууламжийг 10 хувиар нэмэгдүүлэх, Алтай сумын төвийн нүүдлийн ажлын явцыг эрчимжүүлэх, хурлын байгууллагын үйл ажиллагааг өөрчлөн нутаг дэвсгэрийн хөгжлийн бодлогоо зөв тодорхойлох, биелэлтийг зохион байгуулах, практик үйл ажиллагаа болгох, үр дүнг тооцож сурталчлах бүх шатанд өөрчлөн сайжруулах зорилтыг илтгэлдээ дэвшүүлсэн байна.

Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах жилийн ажлын дүн, цаашдын зорилт, аймгийн хөгжлийн хөтөлбөрийн тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваа итгэлдээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгагдсан 84 заалт бүрэн хэрэгжиж 10,0-90,0 хувьтай биелэгдэх шатандаа 232 асуудал, хүлээгдэж байгаа 28 асуудал байгаа ба нийт дүнгээрээ 61,2 хувьтай 2006 онд хэрэгжүүлэх дэвшүүлсэн зорилт 84,7 хувьтай биелүүлж, Жаргалант сумын 960 хүүхдийн сургууль, Зэрэг сумын сургуулийн өргөтгөлийг шинээр барьж Хөгжим драмын театр, Жаргалант сумын I сургууль, Дуут сумын сургууль, Мөст сумын дотуур байр, Буянт сумын соёлын төвийн барилгыг их засвар хийлгэж залуучуудын цэцэрлэгийг 8,5 сая төгрөгөөр тохижуулж, 50361 хүнд 287 тэрбум төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт, 10,5 мянган хүнд 4,9 тэрбум төгрөгийн тэтгэвэр, 656 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 40,4 сая төгрөгийн тусламж үзүүлсэнийг тэмдэглэсэн байна

Мөн орон нутгийн орлогын төлөвлөгөө 6,0 хувиар давж, 2,3 сая мал тоологдож 9 худаг шинээр гаргаж, 25 худаг сэргээн засварлаж, 20,5 мянган тн ургац хураасан нь өмнөх оноос 12,9 хувиар нэмэгдэж байнгын 1017, түр 3574 ажлын байр гарч, 865 хүн гэрээгээр ажиллаж ядуурлын түвшин 16,9 хувиар буурсан, орон нутгийн төр захигааны байгууллага, эрдэмтэд судлаачдын хамтаар Аймгийн 2007-2015 он хүртэлх хөгжлийн хөтөлбөрийг хүнээ эрхэмлэн дээдэлсэн, байгаль орчны онцлогт нийцсэн, өөрийгөө тэтгэсэн эдийн засагтай аймаг болохоор зорилт дэвшүүлж 2007-2010, 2010-2015 гэсэн 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр төлөвлөж боловсруулсаныг тэмдэглэсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргын илтгэлийг хөдөө аж ахуй, байгаль орчны бодлогын байнгын хэсэг хэлэлцэж хурлын ажил тодохой үр дүнд хүрч байгааг сайшаагаад цаашид сумдын ИТХ-ын чадавхийг дээшлүүлэх, байгаль орчны тэнцвэртэй байдлыг хангахад анхаарлаа төвлөрүүлэн ажиллах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд архинд донтосон иргэдийг албадан эмчлэх асуудал, байрыг шийдвэрлэхийг дүгнэлтэнд тусгасан байна.

Төсөв, санхүү, эдийн засгийн байнгын хэсгээс аймгийн Засаг даргын илтгэлийг хэлэлцээд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт 61,2 хувь байгааг дэмжиж нийгмийн бодлогын хүрээний биелэлт 57,5 хувь, үйлдвэрлэл эдийн засаг, дэд бүтцийн



хүрээний зорилт 60,0 хувьтай байгаад анхаарах, шинэ бүтээн байгуулалт тухайлбал хөшөөтийн нүүрсний уурхайн төсөл бий болсон тул хөтөлбөрт нэмэлт хийх, ажилгүйдэл ядуурлыг бууруулахаар хийсэн ажил ард түмний амьдралд төдийлөн тусаагүй байгаа, урт хугацааны хөгжлийн хөтөлбөрийг улс төрийн нам, төрийн бус байгууллагаар хэлэлцүүлээгүй нь учир дутагдалтай болсон тухай дүгнэсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга болон Засаг дарга нарын илтгэлийг хэлэлцээд 2007 оныг “Бүтээн байгуулалт-хөгжлийн жил болгох тухай” болгох тухай тогтоолыг баталсан ба тогтоолд аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2006 онд зохиосон ажлыг хангалттай гэж дүгнэж аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 61,2 хувь хэрэгжсэн байна гэж дүгнэсэн байна

Хуралдааны “Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хөтөлбөр батлах тухай” 5/4 дугаар тогтоолоор Ховд аймгийн хөгжлийн 2007-2015 оны хөтөлбөрийг баталж аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарт хөтөлбөрийг олон нийтэд сурталчилж тухайн жилийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэх, тухай бүр биелэлтэнд мониторинг хийж дүгнэх, салбар байгууллага, аж ахуйн нэгжүүд төлөвлөлтөндөө тусгаж ажиллах талаар даалгасан шийдвэр гаргажээ. Мөн тус хуралдаанаас “2006 оныг ажилгүйдэл, ядуурлыг бууруулах жил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлыг сайшааж амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхийн тоо өмнөх оноос 6,0 хувь бууруулах зорилтыг 19,6 хувь болгон амжилттай хэрэгжүүлсэн байна гэж дүгнэсэн байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2006 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2007 оны үндсэн чиглэл, төсвийн төслийн тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү, эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ үндсэн чиглэлийн 126 зорилт 88,7 хувиар биелэгдэж татвар төлөгчдийн тоо 17,2 мянгад хүрч өргөжин аймгийн төрийн санд төсөвт байгууллагуудын 118 дансыг төвлөрүүлэн зардлын гүйцэтгэлд тавих хяналт өндөржиж санхүүгийн сахилгаа дээшилсэнээр 1,8 тэрбум төгрөгийн орлого бүрдүүлж төлөвлөгөө 5,8 хувиар давж биелж нийт зарлага 1,7 тэрбум төгрөгт хүрч төлөвлөсөнөөс 8,2 хувиар өсөх төлөвтэй байгааг тэмдэглэжээ.

Тайлангийн хугацаанд орон нутгийн хөрөнгө оруулалтаар 219,7 сая төгрөгийн улсын төсвөөр 8,0 тэрбум төгрөгийн, хувийн хэвшлийнхээр 1,6 тэрбум төгрөгийн, төсөл, зээл тусламжаар 0,9 тэрбум төгрөгийн тус тус хөрөнгө оруулалт хийгджээ.

2007 онд 1,1 тэрбум төгрөгийн орлого олж 13,8 тэрбум төгрөг зарцуулахаар, хөрөнгө оруулалт 12,8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөнийг илтгэсэн байна.

Илтгэлийг хэлэлцээд аймгийн 2007 оны төсвийн орлогын доод хязгаарыг 1134,3 сая төгрөгөөр үүнээс татварын орлогыг 1028,2 сая төгрөгөөр, нийт зарлагыг 3094,9 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 468,2 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 1094,2 сая төгрөгөөр, аймгийн төсвийн 2005 оны орлогыг 1091,3 сая төгрөгөөр

зарлагыг 1573,4 сая төгрөгөөр тус тус орон нутгийн төсөв батлах тухай 5/7 дугаар тогтоолоор баталсан байна. Мөн салбарын төсвийг зөвшөөрөх тухай 5/8 дугаар тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2007 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийн 9936,6 сая төгрөгийг сайшаан дэмжиж зөвшөөрсөн байна.

Аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд аймгийн аудитын газраас 2006 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2007 оны төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэлдээ 150 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулах явцад 470,4 сая төгрөгийн зөрчил илэрүүлж 79 тайлан “Зөрчилгүй” стандарт, 53 тайлан “Зөрчилтэй”, 9 тайлан нь “Сөрөг”, 9 тайлан нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгч 8 сум, 34 байгууллагад гүйцэтгэлийн аудит хийж 567,0 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрүүлсэнээс 275,3 сая төгрөгт 121 акт тогтоож, 291,7 сая төгрөгийн зөрчилд 33 албан шаардлага, 34 зөвлөмж гаргаж, 2007 онд орон нутгийн орлогыг 36,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих хяналтыг чангатган өр төлбөрийг барагдуулах, өмчийн сангийн орлого, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх санал дүгнэлтийг оруулсан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийг 2006 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, 2007 оны үндсэн чиглэл, төсвийн төслийн тухай аймгийн Засаг даргын тамгын газрын санхүү эдийн засгийн бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл, Аймгийн аудитын газраас 2006 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2007 оны төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэдийн илтгэлийг төсвийн зарлага санхүүжилтийн хяналтын хэсэг хэлэлцээд аудитын байгууллага хуулийн хүрээнд идэвхитэй үйл ажиллагаа явуулсан, орлого нэмэгдүүлэх, зардлыг бууруулах санал дүгнэлт нь үндэслэлтэй санал болсон, зээл, хандив, тусламжид тавих хяналт сул, тендер шалгаруулалт нууцлагдмал ажиллах боломжгүй компаниудад өгч байна, хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаа ч үр ашиг нь дээшлээгүй, гүйцэтгэгчдийн хариуцлага сул, төсөв хэтрүүлсэн төсөв захирагч нарт хариуцлага тооцох, төсвийн хувиарлалт үндэслэлгүй байна, ангийн орлогыг бүрдүүлэх, зарцуулах журмыг аймгийн ИТХ-аас батлаж мөрдөх, төрийн хяналтын давхардлыг багасгаж үр дүнг аймгийн удирдлагад танилцуулж арга хэмжээ авдаг болох, хөрөнгө бэлтгэсэний дараа шийдвэр гаргадагийг таслан зогсоох, төрийн албаны захирах, захирагдах зарчмыг хэрэгжүүлж ажиллах тухай дүгнэлт гаргасан байна.

Мөн нийгмийн бодлогын байнгын хэсгээс Боловсрол соёл, эрүүл мэндийн салбарын 2007 оны төсвийн төслийг хэлэлцээд төсвийн хувиарлалт зарцуулалтыг оновчтой бус болсоныг анхааруулсан дүгнэлт гаргасан байна.

Аудитын газрын даргын илтгэлийг хэлэлцээд тайланд үнэлэлт өгч санал дэмжих тухай 5/9 дугаар тогтоолоор аймгийн аудитын газар нь 2006 онд Төрийн аудитын, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн хуулиуд болон холбогдох стандарт журмуудын хүрээнд үйл ажиллагаагаа хангалттай явуулж байна дүгнэжээ.

Аймгийн газар зохион байгуулалтын талаар 2006 онд хэрэгжүүлсэн ажил, 2007 онд өмчлүүлэх газрын тухай аймгийн газрын албаны дарга О.Батсайхан илтгэлдээ аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хийх судалгааны ажил хийгдэж ажлаа эхэлсэн, хотын хөгжлийн төлөвлөгөө хэсэгчлэн хийгдээгүй, газрын төсөл сонгон шалгаруулалтанд оролцох санал ирээгүйгээс төлөвлөсөн ажил хэрэгжээгүй, хууль зөрчсөн аж ахуйн зориулалтаар олгосон 9 хүний 0,51 га, 79 өрхийн 4,5 га газрыг эзэмших эрхийг хүчингүй болгосон, 2006 онд 3981 иргэнд 766,18 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд өмчлүүлсэн 2007 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ 55,8 га, аж ахуйн хэрэгцээнд 0,08 га газрыг өмчлүүлэх боломжтой байна гэж үзээд төлөвлөгөөнд тусгуулах санал оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан төрийн байгуулалт хууль зүйн байнгын хэсэг хэлэлцээд ажил үүргийн хүрээнд зарим ажлыг хийсэн боловч иргэдэд газар өмчлүүлэх ажил удаашралтай, түүнийг зохион байгуулан хэрэгжүүлэх талаар санаачилга муутай ажилласан, сумдын ерөнхий төлөвлөгөө бүрэн гүйцэд хийгдээгүй дутагдлыг тэмдэглээд 2007 оны эхний хагас жилд багтаан Ховд хотын кадастрын зураглалыг гаргаж мөрдөх, боломжтой газруудыг айл өрхөд өмчлүүлэх, газрын төлбөрийг бүрэн авдаг болгон хэвшүүлэх, ойжуулалт хийсэн газрын төлбөрийг чөлөөлөх зэргийг санал болгосон байна.

Илтгэлийг хэлэлцээд газар зохион байгуулалтын 2007 онд иргэнд өмчлүүлэх газрыг 1099,29 га, шинээр болон нөхөн эзэмшүүлэхээр 370,5 га, дуудлагын худалдаагаар 14400 кв/м, төсөл сонгон шалгаруулалтаар 2090 кв/м, 40000 айлын орон сууцны хөтөлбөрийн хүрээнд 0,8305 га газрыг төлөвлөн 5/10 дугаар тогтоолоор баталжээ.

Зохион байгуулалтын асуудлын хүрээнд МАХН-ын бүлгээс аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр ажиллаж байсан Ц.Баасандорж Улаанбаатар хотод шилжин ажиллах болсон тул Тэргүүлэгчээс чөлөөлж төлөөлөгч Х.Батболдыг 100,0 хувийн саналаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр нөхөн сонгосон байна.

Хуралдаанаас байнгын хэсгийн бүрэлдхүүнд өөрчлөлт оруулан нийгмийн бодлогын байнгын хэсэгт ахлагчаар Х.Батболдыг, төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хэсэгт ахлагч Б.Батсүх, гишүүн Д.Мурат, ХАА байгаль орчны бодлогын байнгын хэсэгт гишүүн Д.Энхболд, П.Эрвээхэй, төсвийн зарлага, санхүүжилтийн байнгын хэсэгт Ц.Баасандорж нарыг оролцуулан баталсан байна.

Хуралдаанд төсөв хөрөнгө оруулалтын асуудлаар их засвар хийлгэхээр 1 дүгээр цэцэрлэгийн эцэг эхийн хорооны тэргүүлэгчид өргөх бичиг, төсөв хувиарлаж дэмжлэг үзүүлэх тухай хөгжлийн бэрхшээлтэй иргэний холбооны аймгийн зөвлөлийн тэргүүн Б.Сүхбаатар,

тойрогтийн услалтын хоолойг сайжруулах, халуун усны газар барих, гүнийн худаг гаргах, автобусны үйлчилгээг бий болгох талаар төлөөлөгч Д.Нямлхагва хүсэлт, багийн засаг даргын ажил болон бэлчээр ашиглалтыг сайжруулах саналын талаар Чандмань сумын иргэн Н.Дамдиндорж захидал тус тус ирүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 5 дугаар хуралдаанд нийт 30 төлөөлөгчийн 27 буюу 90,0 хувь нь оролцож урилгаар 114 хүн оролцсоноос төсвийн байгууллагын ажилтан 85, иргэд 29 байгаа ба хуралдаанд 35 хүн үг хэлж нийт 6 асуудал хэлэлцэн 13 тогтоол баталсан байна.

#### **Аймгийн ИТХ-ын 6 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 5 дугаар сарын 23-ний өдрийн 141 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын ИТХ-ын 6 дугаар хуралдааныг 2006 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Ховд хотод хуралдуулж “Бүтээн байгуулалт-хөгжлийн жил”-ийн ажлын явц түүнийг эрчимжүүлэх тухай аймгийн Засаг дарга Г.Нямдаваагийн илтгэлийг хэлэлцэхээр товлон зарласан байна.

Мөн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 143 дугаар тогтоолоор зохион байгуулалтын тухай асуудлыг нэмж хэлэлцэхээр шийдвэрлэжээ.

Тус 6 дугаар хуралдаан 31 төлөөлөгчийн 23 буюу 79,3 хувийн ирцтэй хуралджээ. Хуралдаанд 112 хүн урилгаар оролцсоноос 63 хүн төсвийн байгууллагын ажилтанууд байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан байнгын дэгийг мөрдөж харин энэ удаагийн хуралдааны онцлогийг харгалзан Тэргүүлэгчид, төлөөлөгчид дэмжсэнээр “хэлэлцэх асуудлын дараалалд оруулсанаар шийдвэрлэх” нэмэл өөрчлөлт оруулсан байна.

Төлөөлөгчдийн 86,3 хувийн саналаар хэлэлцэх асуудал, дотоод журам, ажлын албыг 2 дугаар тогтоолоор баталсан байна.

Зохион байгуулалтын асуудалд ИТХ-ын Тэргүүлэгчийг нөхөн сонгох, ИТХ-ын Тэргүүлэгчээс чөлөөлөгдөх хүсэлт гаргасан Төлөөлөгч, тэргүүлэгч Ш.Батхишигийн хүсэлтийн тухай, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн шинэчилэн найруулсан хуулинд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид, Хурлын даргыг нийцүүлэн сонгох тухай асуудлуудыг оруулсан байна.

Хуралдааны ажлын албаны нарийн бичигээр Ч.Сүрэнжав аймгийн Төрийн захиргаа удирдлагын хэлтсийн мэргэжлмтэн, С.Дорж нийгмийн бодлого зохицуулалтын хэлтсийн ажилтан Ш.Ичинхорлоо төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан, Редакцийн комисст Ч.Цэрэнчимэд ерөнхий аудитор, Б.Шоовдой төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан, хуралдааны тэмдэглэл хөтлөгчөөр М.Отгоншиг төрийн захиргаа удирдлагын хэлтсийн ажилтан нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Н.Дамбаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Аймгийн Засаг дарга илтгэлдээ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2,6 жилийн хугацаанд 75,0 хувийн биелэлтэнд хүрч санхүүгийн сахилга дээшилж ажилгүйдэл ядууралын түвшин 16,9 хувиар буурч аймгийн ДНБ-ний түвшин 16,8 хувиар нэмэгдэж, эхний хагас жилийн урьдчилсан дүнгээр 3,1 сая мал тоолуулахаар тооцогдож газар тариалангийн үйлдвэрлэл 1935 га талбайд тариалалт хийж өнгөрсөн оноос 79,6 га-гаар нэмэгдэж эхний 5 сарын байдлаар төсөвт 183,2 сая төгрөг орж 3,4 хувиар давж биелсэн тухай тэмдэглэсэн байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний талаар энэ онд хийгдэх орон нутгийн төсвөөс 888,8 сая төгрөг, улсын төсвөөс 18,2 тэрбум төгрөг, Зээл тусламжаар 1,8 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлж 107 төсөл, арга хэмжээ 25 тоног төхөөрөмж худалдан авахаар батлагдсаны тендер сонгон шалгаруулалтын ажил 96,0 хувьтайг дүгнээд орон нутгийн хөрөнгө оруулалтын арга хэмжээ 9 төсөл бүрэн хэрэгжиж 16 төсөл хэрэгжих шатандаа, 1 төсөл хэрэгжээгүй, Эрүүл мэндийн яамны багцаар 8 төсөл бүрэн хэрэгжиж, Боловсрол соёл шинжлэх ухааны яамны төсвийн багцаас 12 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж бусад яамдын 36 төсөл арга хэмжээнээс 16 нь бүрэн хэрэгжиж 19 төсөл хэрэгжих шатандаа байгааг дүгнэж илтгэсэн байна.

Бүтээн байгуулалт хөгжлийн жилийн хүрээнд Дөргөний УСЦ-ын барилгын ажлын 75,0 хувийг гүйцэтгэн тоног төхөөрөмжийг татан авч 11 сард эхний генераторийг ашиглалтанд оруулах, 6 суманд 310,7 км цахилгаан дамжуулах шугам татаж дэд станц барих, хашаатын давааны 11 км замын их засвар хийх, Булган-Үенч-Ховдын чиглэлд 60 км хатуу хучилттай зам тавих, аймгийн төвд хүүхэд залуучуудын ордон барих, Нэвт рашаан сувилалыг засварлан ашиглалтанд оруулах, хотын дотор 2 км асфальтан зам тавих, 7 сумын суудлын авто машин, 3 сумын конторын барилга, загвар мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв байгуулах, Мэргэжлийн хяналтын газрын контор, 40 айлын орон сууц барих зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Илтгэлдээ цаашид бүтээн байгуулалтын ажлын явцад тавих хяналтыг сайжруулж мэргэжлийн комисс байгуулан ажиллуулах, мэргэжлийн ажилчдыг бэлтгэх, улсын төсвийн хөрөнгө оруулалтанд тавих хяналтын зардлыг орон нутагт олгох, хэрэгжиж эхлээгүй арга хэмжээг яаралтай эхлүүлэх, захиалагчдын зүгээс тавих хяналтыг сайжруулах, ажилд зохих стандарт норм нормативуудыг мөрдүүлэх талаар зорилтуудыг дэвшүүлсэн байна.

Хуралдаанд 17 үг хэлж санал шүүмжлэл гарган “Бүтээн байгуулалт хөгжлийн жил”-ийн ажлын явцыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 05 тоот тогтоолыг баталсан байна.

Тус тогтоолд энэ онд улсын болон орон нутгийн, гадаад, дотоодын зээл тусламж, төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар санхүүжих бараа, ажил үйлчилгээний ажлын эхлэл явц зохих хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулагдаж байна гэж дүгнэсэн байна.

Тус тогтоолд аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэвт бүтээн байгуулалт хөгжлийн жилийн ажлын явцыг Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж эрчимжүүлэн тавих хяналтыг сайжруулж иргэний нийгмийн байгуулагуудын оролцоог хангаж үр дүнг хэвлэл мэдээлэлийн хэрэгсэлээр сурталчилах, аймгийн Засаг дарга Г.Нямдаваа, сумдын Засаг дарга нарт хөрөнгө оруулалтын ажлын явцад орон нутгаас тавих хяналтыг эрс сайжруулах, байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүйгээр гүйцэтгэх, ажлын байр нэмэгдүүлэн хөгжлийг тэтгэх бодлогыг хэрэгжүүлэн хөрөнгө оруулалтын ажлыг 2007 оны 11 дүгээр сарын 15-ний дотор дуусгах заалтыг тогтоолд тусгасан байна.

Хуралдааны 4 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээс Засаг даргын тамгын газрын дарга Л.Батбаяр, Ш.Батхишиг нарыг чөлөөлсөн байна.

ИТХ-д суудалтай МАХН-аас тэргүүлэгч Н.Батаа нас барсан, Л.Батбаяр чөлөөлөгдсөн тул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр төлөөлөгч Т.Баярсайхан, Д.Батчулуун нарыг сонгохоор нэрийг дэвшүүлсэн байна. Мөн цөөнхийн бүлгийн хуралдаанаас Тэргүүлэгчээр төлөөлөгч Л.Галбадрахыг сонгуулах санал дэвшүүлсэн байна.

Тэргүүлэгчдийг сонгох тооллогын комиссын даргаар Ч.Цэрэнчимэд /ерөнхий аудитор/, гишүүдэд Б.Шоовдой /аймгийн Засаг даргын тамгын газрын ажилтан/, Ш.Отгонбаяр /Уенч сумын ИТХ-ын дарга/ нарыг сонгосон байна.

Тухайн үед аймгийн ИТХ-ын тэргүүлэгчээр МАХН-аас 2 хүн, цөөнхийн бүлгээс 1 хүн сонгогдохоор шийдвэрлэсэн тул зөвхөн цөөнхийн бүлгээс нэр дэвшсэн Л.Галбадрах болон төлөөлөгчдөөс нэр дэвшсэн Д.Нямлхагва нарыг оролцуулан тооллого явуулж нийт санал хураалтанд 20 төлөөлөгч оролцож 70,0 хувиар Л.Галбадрахыг дэмжсэн байна.

Хуралдааны 7 дугаар тогтоолоор Д.Батчулуун, Т.Баярсайхан, Л.Галбадрах нарыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчээр сонгосон байна.

Хуралдааны 8 дугаар тогтоолоор Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай шинэчлэн найруулсан хуульд нийцүүлэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн дарга О.Ширэндэвийг аймгийн ИТХ-ын даргаар сонгосон байна.

Хуралдаанд хэлэлцсэн асуудлуудтай холбогдуулан 21 хүн асуулт асууж, 17 хүн санал, шүүмжлэл хэлсэн байна.

#### **Аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 218 тоот тогтоолоор аймгийн ИТХ-ын 7 дугаар хуралдааныг 10 дугаар сарын 5-ны өдөр хуралдуулж “аймгийн 2007 оны төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт, бүтээн байгуулалтын ажлын явцын тухай” хэлэлцэхээр товлон зарласан байна.

Хуралдаан 22 төлөөлөгч буюу 75,8 хувийн ирцтэйгээр эхэлж үйлчлэх ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, У.Цэрэнтогтох, редакцийн комиссоор Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа

удирдлагын хэлтсийн ажилтан Б.Шоовдой, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас баримт бичиг боловсруулах ажлын хэсгийг Л.Батбаяр /Засаг даргын Тамгын газрын дарга/ -аар ахлуулан 5 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа хуралдаанд тавьсан “Аймгийн 2007 оны төсөвт оруулах нэмэлт өөрчлөлт, бүтээн байгуулалтын ажлын явцын тухай” илтгэлдээ 2007 оны батлагдсан төсөвт цалин хөлсний зардлыг 50,5 сая төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлд 13,3 сая төгрөгөөр, албан томилолтын зардлыг 1,3 сая төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшуулалыг 47,9 сая төгрөгөөр нийт 113,1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Тус нэмэгдүүлсэн төсвийн зарлагын эх үүсвэрийг НӨАТ-ын шилжүүлгийн орлогоор 66,3 сая төгрөгийг, санхүүгийн дэмжлэгээр 46,8 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр баталсан байна.

Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татварыг 100,0 сая төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагын орлогын албан татварыг 40,0 сая төгрөгөөр, ноогдол ашгийг 2,1 сая төгрөгөөр нийт 142,2 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгосон байна.

Орон нутаг дахь улсын төсвийн байгууллагуудын 2007 оны төсөвт нийт дүнгээрээ 452,3 сая төгрөгөөр нэмэгдүүлэн тодотгож сумдад олгох санхүүгийн дэмжлэгийг 99420,6 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 26 арга хэмжээ хэрэгжүүлэхээс 77,0 хувь нь бүрэн дуусч, 23,0 хувь нь 50,0-иас дээш хувийн биелэлттэй байгаа ба санхүүжилтийн хувь нь 91,2 хувийн биелэлттэй байгаа тухай илтгэлдээ тэмдэглэсэн байна. Мөн эрүүл мэндийн салбарын хөрөнгө оруулалт 75,0 хувь, боловсролын салбарын хөрөнгө оруулалтын 58,3 хувь, бусад салбарын хөрөнгө оруулалт 55,0 хувийн биелэлттэй байгаа тухай илтгэсэн байна.

Тус хуралдаанаас анх удаа багийн ИНХ-ын дарга нарт ажлын урамшуулал олгохоор 47,9 сая төгрөг баталжээ.

Хуралдаан “Бүтээн байгуулалт- хөгжлийн жил”-ийн ажлын явцыг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай тогтоол баталж хөрөнгө оруулалтын ажлын явцад мэргэжлийн хяналтын газар, барилга хот байгуулалтын албанаас тавих хяналтыг эрс дээшлүүлэн чангатгах, хүлээн авах аймаг, сумын комиссын хариуцлагыг дээшлүүлэх, гарсан алдаа дутагдлыг яаралтай засуулах, ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгчид, Засаг даргын Тамгын газраас холбогдох агентлаг албадаас бүрдсэн ажлын хэсэг байгуулж ажлын явцтай танилцан дүгнэж дэмжлэг туслалцаа үзүүлэх зэрэг заалтуудыг тусгасан байна.

Мөн аймгийн ИТХ-ын хороодыг нийгмийн бодлогын, төрийн байгуулалт хууль зүйн, төсөв санхүү эдийн засгийн бодлогын, хөдөөгийн бодлого, байгаль орчны бодлогын, төсвийн зарлага, санхүүжилтийн хяналтын зэрэг 5 хороотой ажиллахаар баталжээ.

Хуралдаанд аймгийн Ардчилсан намаас аймгийн ИТХ-ын 2 дугаар тойргийн төлөөлөгч нас барсан, 20 дугаар тойргийн төлөөлөгч Ц.Баасандорж, 6 дугаар тойргийн төлөөлөгч Н.Баатарням, 19 дүгээр тойргийн төлөөлөгч Ш.Батхишиг нар Улаанбаатар хотод шилжсэн байхад нөхөн сонгууль явуулахгүй орон нутгийн сонгуулийн хуулийг ноцтой зөрчиж иргэд сонгогчдын эрх ашиг зөрчигдөж байгааг эсэргүүцэж дээрхи тойргуудад нөхөн сонгууль явуулахыг шаардсан мэдэгдэл ирүүлсэн байна.

Хуралдаанд 45 хүн урилгаар оролцож үүнээс төсөвт байгууллагын ажилтан 40, иргэн 5 оролцсон ба 7 хүн асуулт асууж, 18 хүн үг хэлжээ.

### **Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаан**

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2007 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 259 дүгээр тогтоолоор аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдааныг 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдөр хуралдуулж

1. Аймгийн ИТХ-ын тайлан, НӨУЁБ-ын эрх зүйн байдлыг дээшлүүлэх тухай,
2. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр бүтээн байгуулалтын ажлын дүн, цаашдын зорилтын тухай илтгэл
3. Аймгийн эдийн засаг, нийгмийн болон төсвийн 2007 оны гүйцэтгэл, 2008 оны үндсэн чиглэл төсвийн төслийн тухай илтгэл
4. Аудитын 2007 оны тайлан, 2008 оны төсвийн төсөлд болон төсвийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай илтгэл
5. Иргэнд газар өмчлүүлэх болон газар зохион байгуулалтын 2008 оны төлөвлөгөөний тухай илтгэлүүдийг хэлэлцүүлэхээр зарласан байна.

Хуралдаан аймгийн ИТХ-ын 2004 оны 2 дугаар хуралдаанаас баталсан дэгээр хуралдаж ажлын албаны нарийн бичгийн даргаар аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Сандагсүрэн, У..Цэрэнтогтох, аймгийн аудитын газрын ахлах шинжээч Б.Түмээ, редакцийн комиссоор аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн захиргаа удирдлагын хэлтсийн түшмэл Б.Шоовдой, аймгийн боловсрол соёлын газрын дарга Б.Хашэрдэнэ, тэмдэглэл хөтлөгчөөр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах ажилтан Б.Энхтуяа нар ажилласан байна.

Хуралдаанаас гарах тогтоол шийдвэрийн ажлын хэсгийг аймгийн Засаг дарга Г.Нямдаваагаар ахлуулан 10 хүний бүрэлдхүүнтэй байгуулжээ.

Аймгийн ИТХ-ын дарга О.Ширэндэв илтгэлдээ Аймгийн ИТХ Монгол улсын Үндсэн хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон Нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах зарчимд тулгуурлан нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн ирээдүйн төлөв, дэд бүтэц, газар зохион байгуулалт, хот байгуулалт, байгаль орчныг хамгаалах, сахилга дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, зах зээлийн



хүрээ өргөтгөх, бизнесийн таатай орчинг бүрдүүлэх замаар ард иргэдийн ая тухтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, ахмадуудын нийгмийн хамгааллыг өргөтгөх, санхүү, эдийн засгийн хүндрэлтэй нөхцөлд төсвийг үр ашигтай зарцуулах, хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх зэрэг аймгийн хэмжээнд тулгарсан асуудлуудыг судлан шийдвэрлэхэд өөрийн нөөц боломж, онцлогийг харгалзан бодлого, чиглэлээ тодорхойлон ажиллаж байгаа бөгөөд аймгийн ИТХ-ын сонгуулийн эрхийн хугацааны үйл ажиллагааны Үндсэн чиглэлийн 147 заалт зорилт 92,2 хувийн биелэлттэй байгааг дүгнэжээ.

Монгол орны хувьд нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн 1500 ам.долларт хүрч, 68.5 мянган ажлын байр шинээр бий болж, өнгөрсөн оныхоос ажилгүйчүүдийн тоо зохих түвшинд буурч, хүүхэд, гэр бүл, ахмадуудыг дэмжсэн нийгмийн хамгааллын шинэ шинэ бодлого явуулж, төрийн албан хаагчдын цалин, өндөр настны болон бусад тэтгэвэр тэтгэмжийг нэмэгдүүлэх, тэтгэврийн зөрүүг багасгах арга хэмжээг ээлж дараатай авч хэрэгжүүлсэн, багш, эмч нарыг хөдөөд тогтвортой ажиллуулах бодлогын хүрээнд орон нутагт ажилласан таван жил тутамд зургаан сарын цалинтай тэнцэх тэтгэлэг, шинээр мэндэлсэн хүүхдүүдэд нэг удаа болон сар улирал тутам тэтгэлэг олгож байгаа дэвшил бий болж, хүн амын аж амьдралыг тасралтгүй дээшлүүлэх улмаар улс эх орныхоо тогтвортой өсөлтийг хангах бодлого бодит ажил болж байна.

Манай аймгийн хувьд аймгийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл, орон нутгийн өмнө тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй шийдвэрлэх үүднээс 2007 оныг “Бүтээн байгуулалт- хөгжлийн жил” болгон тодорхой зорилт дэвшүүлэн ажилласнаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, гадаадын зээл, тусламжийн 106 төсөл арга хэмжээнд 28.5 тэрбум төгрөгийн ажил хийгдэж 300 шахам объектийг шинээр буюу шинэчлэн сайжрууллаа.

Эдгээр зорилт, бодлого, үйл ажиллагааны үр дүнд ажилгүйдэл, ядуурлын түвшин 1.0 хувь буурч, дотоодын нийт бүтээгдэхүүн 11.0 орчим хувь өсч, санхүүгийн сахилга хариуцлага сайжирч, ард иргэдийн амьдрал ахуй болон аймаг, орон нутгийн хөгжилд нэлээд ахиц өөрчлөлтүүд гарсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хуралдааны чөлөөт цагт тэргүүлэгчид 38 удаа хуралдаж санхүү, төсөв, өмч, байгаль экологи, боловсрол, соёл, урлаг, эрүүл мэнд, спорт, нийгмийн халамж, нийгмийн даатгалын удирдах арга барилыг сайжруулах, НААҮ, дулаан, цахилгаан, холбоо мэдээлэл, авто зам засвар зэрэг дэд бүтцийг өргөтгөх зэрэг ажил хэрэгч асуудлаар удирдлагуудын илтгэл, мэдээлэл хэлэлцэх, шалгалт, үнэлгээний дүнтэй танилцах, аймаг, сум, багийн хурлыг чадавхижуулах, аймаг, сумын Засаг дарга нарын бодлогын хэрэгжилтийг идэвхжүүлэхэд чиглүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид Булган сумын 11 жилийн дунд сургуулийг Ардын багш Бадамсэдийн нэрэмжит болгох, V Ари гэгээний санаачлага, оролцоотойгоор барьж

байгуулсан Цаст-Алтай цогцолбор сургуулийн II байр “хөх байшин”-г боловсролын байгууллагад ашиглуулах замаар хамгаалалтанд авах, иргэдийн угийн бичгийг хөтлөх ажлыг зохион байгуулах, Алтай сумын Алаг тэшт уул, Үенч сумын Үенч, Улиастай голуудын зарим газар нутгийг орон нутгийн хамгаалалтанд авах, ахмадын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд сургалт явуулах, халамж үйлчилгээний танхим байгуулах, “Үндэсний бөх, бөхийн спортын хөгжлийг дэмжих”, “амны хөндийн эрүүл мэнд” дэд хөтөлбөр, “Оюунлаг Ховд” хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг байгуулах, аймгийн эдийн засаг, нийгмийг 2007 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, төсвийн бүрдүүлэлт, санхүүжилтийн тухай, эдийн засаг, нийгмийг 2008 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, 2008 оны төсвийн төсөл боловсруулсан дүн, Ховд хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийлгэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, жижиг дунд үйлдвэрлэл, хоршоог дэмжих, газрын нэгдмэл сангийн тухай, төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын 2006 оны жилийн эцсийн тайланд баталгаажуулах аудит хийсэн болон тайлан тэнцэл хүлээж авсан дүнгийн тухай, Үндэсний их баяр, наадмын бэлтгэл ажлын тухай, Иргэдийн нийгмийн хамгаалал үйлчилгээний хүртээмжийг сайжруулах талаар зохиож байгаа ажлын үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай, гадаадад ажиллах хүч гаргах, мэргэжил дадлага эзэмшүүлэх ажлын явц, үр дүнгийн тухай, кадастрын зураглал хийлгүүлэхэд дэмжлэг үзүүлэх, гадна реклам, мэдээллийн байгууламжийн талаар байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дагаж мөрдөх журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, орон нутгийн өмчийн асуудлууд, Төрийн дээд шагналд тодорхойлох, аймгийн Хүндэт иргэн, Хүндэт тэмдэгээр шагнах, Иргэдийн санал хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэх зэрэг аймгийн тулгамдсан болон стратеги, үйл ажиллагааны олон чухал асуудал арга хэмжээг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Аймгийн хэмжээгээр 2007 онд 106 төсөл арга хэмжээнд 28.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдэж аж үйлдвэрийн салбарынхан 1 тэрбум 862.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 1 тэрбум 600,6 сая төгрөгийн борлуулалт хийж, тээвэрчид 450.1 мян.тонн ачаа тээвэрлэж, 54105.0 мянган тонн км ачаа эргэлт хийж 6530.0 мянган хүн.км зорчигч тээвэрлэж, нийт 170.8 сая төгрөгийн орлоготой ажиллажээ.

Хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь өмнөх онтой харьцуулахад 2 дахин нэмэгдэхийн хэрээр уг ажлыг зохион байгуулах, төрийн дэмжлэг үйлчилгээг сайжруулах, хяналт үнэлгээг чанартай гүйцэтгэх гээд бүс нутгийн ач холбогдолтой Дөргөний УЦС, Булган–Алтай сумын босоо тэнхлэгийн зам барих, Манхан, Дарви, Зэрэг, Чандмань сумын ЦДШ зэрэг томоохон хөрөнгө оруулалтыг хийсэн нь олны сэтгэлд хүрсэн бүтээн байгуулалтууд болсон байна.

Аймгийн Засаг даргын санаачлагаар Тайваны Төвд - Монголын хорооны зохион байгуулалт, Тун эмнэлгийн өгөөмөр сэтгэлийн тусламжаар Компьютер томографийн 1.2 миллиард төгрөгийн үнэ бүхий аппаратыг аймгуудаас анх удаа БОЭТ-д суурилуулсан байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 25 сургуулийн 662 бүлэгт 21865 хүүхэд суралцах болж 6 настай 720 хүүхдүүдийг сургуульд элсүүлж, сургуулийн насны хүүхдийн хамралт 96 хувь, 27 цэцэрлэгийн байнгын бүлэгт 2862 хүүхэд хамруулж нийт сумдад улирлын чанартай гэр цэцэрлэг ажиллуулснаар сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт 55 хувь болж нэмэгдлээ. Сургалтын шинэ арга технологийг нэвтэрүүлэх, багшийн заах арга, ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн 31 удаагийн сургалтанд 887 багшийг хамруулж, Боловсролын тухай хуульд заасны дагуу хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа багшид олгох тэтгэмжинд нийт 717 багшийг хамруулан 456.8 сая төгрөг олгосон байна.

Манай аймаг 2544.8 мянган мал тоолуулж, өнгөрсөн оны мөн үеийнхээс 10.9 хувь буюу 251.1 мянгаар 5 төрөл дээрээ өссөний дотор тэмээ 2.4, адуу 7.1, үхэр 8.8, хонь 10.0, ямаа 12.1 хувиар тус тус өссөн байна. Жаргалантаас бусад бүх сум малаа өсгөсний дотор Алтай, Булган, Дарви, Дөргөн, Дуут, Зэрэг, Манхан, Мянгад, Мөнххайрхан, Цэцэг, Чандмань сум таван төрөл дээр нь өсгөж, Буянт, Мөст, Үенч, Эрдэнэбүрэн, Ховд сум тэмээ, Үенч сум үхэр, Жаргалант сум бүх төрөл дээр малаа хорогдуулсаныг дүрдсэн байна.

ХАА-н салбарт хийгдэж буй томоохон хөрөнгө оруулалтын нэг нь бэлчээрийн усан хангамжийг шийдвэрлэх зорилгоор улсын төвлөрсөн төсвийн 652.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж 40 худаг шинээр гаргаж, 27 худаг сэргээн засварлаж, төсвийн тодотголоор шинээр 14 худаг, нийт 81 худаг гаргаж 406.9 мянган га бэлчээр буюу 388.8 мянган малын усны хангамжийг шийдвэрлэсэн байна.

2007 оны төсвийн орлогын бүрдүүлэлт 1 тэрбум 305.2 сая төгрөгт хүрч 33.8 сая төгрөгөөр давахаар, төсвийн зарлага 15.5 тэрбум төгрөгт хүрч 102.6 сая төгрөгөөр давж төсвийн санхүүжилтын түвшин дээшилсэн дүнгээр шинэ оныг угтах болж, түүнчлэн анхан шатны бүртгэлийн хөтлөлт 89, нягтлан бодох бүртгэл 91,0 хувьтай болж урьд оноос өссөн байна.

Аймгийн төвийн төсөвт бүх байгууллагыг цахим тооцоололд бүрэн шилжүүлж аж ахуйн нэгжийн 97,0 хувь нь буюу 466 нь тайлангийн нэгтгэлд орж татварын орлогын тооцоонд хамрагдсан тухай илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Аймгийн ИТХ-ын даргын илтгэлд төрийн байгуулалт хууль зүйн хорооноос аймгийн хэмжээнд тулгарсан асуудлуудыг судлан шийдвэрлэхэд өөрийн нөөц боломж, онцлогийг харгалзан, бодлого чиглэлийг тодорхойлон зохион байгуулж төлөвлөсөн ажил 95,3 хувийн биелэлттэй байгаа нь ИТХ, төлөөлөгчид болон нутгийн захиргааны байгууллагууд, аж ахуйн нэгж, иргэдийн ажлын үр дүнтэй шууд холбоотой гэж дүгнэжээ.

Аймгийн Засаг дарга Г.Нямдаваа “Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, бүтээн байгуулалт хөгжлийн жилийн ажлын дүн, цаашдын зорилтын тухай” итгэлдээ аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан 240 заалт бүрэн хэрэгжиж, биелэгдэх шатандаа буюу 30,0-90,0

хувийн хэрэгжилттэй 104 асуудал хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 3, нийт дүнгээрээ хөтөлбөрийн биелэлт 2005 онд 32,1 хувь, 2006 онд 61,2 хувь, 2007 онд 92,6 хувиар биелүүлсэн байна.

Хөдөөгийн 62 багийн засаг даргад албан ажлын хэрэгцээнд зориулан унааны мотоцикл олгож 7 сумын 26 багийн төвийн барилгыг 62,0 сая төгрөгөөр засварлаж нөхцөлийг сайжруулж 9 сумын Засаг даргын тамгын газрын суудлын автомашиныг шинэчилж тоног төхөөрөмж, ширээ сандлыг шинэчлэхэд 70,0 сая төгрөг зарцуулсан байна.

Энэ онд аймаг 28,3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэнээс орон нутгийн төсвөөс 888,8 сая төгрөг, улсын төсвөөс 22,6 тэрбум төгрөг, хувийн хэвшлийн хөрөнгөөр 2,6 тэрбум төгрөг, зээл тусламжаар 2,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэнээс 93,5 хувийн биелэлттэй байгаа тухай дурьдаад Ү хуралдаанаас зарласан “Бүтээн байгуулалт-хөгжлийн жил”-ийн хүрээнд Манхан-Чандмань сумын 15 квт-ын 65 ЦДАШ дэд станц, Манхан-Зэрэг, Зэрэг-Дарви сумын 35 кв-тын 134 км ЦДАШ, дэд станц, Мяннад-Манхан сумын 110 квт-ын 121 км ЦДАШ, дэд станц, Булган сумын 04-ийн шугам, Булган-Ховд хотын чиглэлийн 60 км асфальтан зам, Цэцэг суманд нар дизель хосолсон цахилгаан станц, Эрдэнэбүрэн сумын УЦС-ын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, Алтай, Ховд, Цэцэг сумын цаг уурын станцын барилга угсралтын ажил, Эрүүл мэндийн газар, Мөнххайрхан сумын хүн эмнэлгийн болон Бугат багийн өрхийн эмнэлгийн засвар, Манхан сумын болон жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн барилгын засвар, Мөнххайрхан, Үенч, Ховд, Манхан, Жаргалант сумын 2 дугаар дунд сургуулийн барилгын засварууд, Дөргөн, Мөст сумын соёлын төвийн барилгын засварын өргөтгөл, Мянгад сумын төмөр бетон гүүр, Хотын доторхи 3,2 км зам, Буянт сумын Засаг даргын Тамгын газар, соёлын төв, Манхан, Мөнххайрхан сумын УЦС-ын засвар, Хүүхэд залуучуудын ордон зэрэг ач холбогдол бүхий 28 томоохон ажлыг нэмж гүцэтгэсэн байна.

Аймгийн хэмжээнд 9313 малчин өрхөд 21992 хүн мал аж ахуйн салбарт ажиллаж 2,5 сая мал тоолуулсан нь өмнөх оноос 10,9 хувиар өссөн байна.Тус салбарт 54 худаг шинээр гаргаж 27 худаг шинээр засварласан байна.

Газар тариалангийн салбарт 2641,4 га талбайд тариалалт хийж 20,9 мянган тн ургац хураасан байна.

Тайлангийн жилд сургууль завсардалт өмнөх оноос 40,0 хувиар буурч сургуулийн насны сургуульд хамралт 96,0 хувьд хүрч сумдад гэр цэцэрлэг ажиллуулсанаар сургуулийн өмнөх боловсролын хамралт 50,0 хувьд хүрсэн байна. Бага ангийн сурагчдын үдийн цай хөтөлбөрт 1-4 ангийн 8984 сурагч хамрагдан 239,9 сая төгрөг төсөвлөн зарцуулсан байна.

Эмнэлгийн үзлэг өмнөх оноос 1,4 хувиар нэмэгдэн аймгийн хэмжээнд халдарт өвчний тохиолдол 366 гарч өмнөх оны мөн үеийнхээс 312 тохиолдолоор буурч 5 хүртэлх насны

хүүхдийн эндэгдэл тогтвортой буурч 1000 амьд төрөлтөнд 21,8 болж 2004 онтой харьцуулахад 4,8 пунктээр нялхасын эндэгдэл 20,5 болж 2,0 пунктээр буурсан байна.

Нийтийг хамарсан зохион байгуулалттай ажилд 820 ажилгүй иргэдийг түр ажлын байраар ханган 385 иргэдийг 501,5 сая төгрөгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зээлд хамруулсанаар 572 ажлын байр шинээр бий болсон байна.

Аймгийн хэмжээнд 483 гэмт хэрэг гарч өмнөх оноос 69 хэрэг буюу 14 хувиар өссөн тухай илтгэлдээ тэмдэглэсэн байна.

Аймгийн Засаг даргын илтгэлтэй холбогдуулан нийгмийн бодлогын хороо дүгнэлт гаргаж төрийн ажил үйлчилгээг явуулахад нэн шаардлагатай техник, тоног төхөөрөмж, орчин нөхцөлөөр хангасан, төрийн албан хаагчийг сурч боловсрох, мэргэжил дээшлүүлэхэд сайтар анхаарсан, аймгийн гадаад харилцаанд ахиц гарсан, бүтээн байгуулалтын ажлыг цаг хугацаа алдалгүй шуурхай зохион байгуулсан зэрэг ололттой талуудыг дурдаж гэмт хэрэг өссөн, бүх шатанд хариуцлагын тогтолцоо сул, сургуулийн сургалтын үйл ажиллагаа сул, эрүүл мэндийн үйл ажиллагаанд өөрчлөлт гараагүй, жижиг дунд үйлдвэрлэлийн хөгжил сул байгаад анхаарч ажиллах шаадалагатай байгааг дүгнэсэн байна.

Мөн Ховд аймгийн нийгэм эдийн засгийн байдал, засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, аймгийн удирдлагын үйл ажиллагаанд Ховд аймгийн ардчилсан намаас өгөх үнэлэлт, дүгнэлтэд эдийн засгийн өсөлтийн үр шимийг иргэдийн дийлэнхий олонхи нь хүртэж чадахгүй байгаа болон ажилгүйдэл ядуурлыг бууруулж чадаагүй бөгөөд барааны үнэ галзуурсан мэт өсөж байгаа нь ажилтай ядуучуудын эгнээг бий болгож хөдөлмөрийн үнэлэмжгүй байдал үүсэж байна. Манай аймагт авилга, хээл хахууль газар авч албан тушаалтануудад хууль үйлчидэггүй болж аймгийн нутаг дэвсгэрт 2000-2004 онд 45, 2005-2007 онд 101 лицензийг гадаад, дотоодын компаниудад олгосон нь хяналт алдагдаж Хөшөөтийн уурхайн компани Ярантын хилээр 74,2 тн А зэрэглэлийн онцгой хортой бодисууд оруулж ирсэн байна. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг 63,7 хувьтай байгааг дурьдаад Г.Нямдаваа, О.Ширэндэв нар аймаг, орон нутгийг цаашид удирдан ажиллах ёс суртахууны эрхгүй гэж үзэх үндэслэлтэйг тэмдэглэсэн байна.

Аймгийн ИТХ-ын дарга болон Засаг даргын илтгэлийг хэлэлцээд “үйлдвэрлэл-үндэстэн, ястаны өв соёлын хөгжлийг дэмжих” болгох тухай тогтоолыг баталсан ба тогтоолд аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны үндсэн чиглэл 92,44, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 91,5 хувьтай хэрэгжсэнийг үндэслэн ИТХ, Засаг даргын үйл ажиллагааг “хангалттай” гэж дүгнэж 2008 оныг “Үйлдвэрлэл-үндэстэн, ястаны өв соёлын хөгжлийг дэмжих жил” болгон зарласан байна.

Аймгийн эдийн засаг, нийгмийн болон төсвийн 2007 оны гүйцэтгэл, 2008 оны үндсэн чиглэл, төсвийн төслийн тухай аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү эдийн засаг бодлого зохицуулалтын хэлтсийн дарга Д.Алтангэрэл илтгэлдээ хүлээгдэж байгаа

гүйцэтгэлээр орон нутгийн төсөвт нийт орлогоор 3,2 тэрбум төгрөг орохоос 3.3 тэрбум төгрөг, татварын орлогоор 553,7 сая төгрөг орохоос 594,4 сая төгрөг төвлөрч байгаа бөгөөд Мөст сум 6,0 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөөг таслахаар бусад сумууд 2,2-27,1 хувиар давуулж биелүүлэн, улсын төсөвт төвлүүлэх орлого 35,1 хувиар давж биелэхээр байгааг тэмдэглэжээ.

Тайлангийн хугацаанд 2,4 тэрбум төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлэхээр батлагдсанаас 2.5 тэрбум төгрөгийн санхүүжүүлж 45,4 сая төгрөгийн өр гарахаар тооцсоныг тэмдэглэсэн байна. Мөн 2008 онд орон нутгийн нийт орлогоор 4,3 тэрбум төгрөгийн орлого үүнээс татварын орлогоор 543,7 сая төгрөг нийт зардлыг 20,5 тэрбум төгрөг үүнээс урсгал зардал 3,3 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн нь ДНБ-ний 40,0 хувьд хүрсэн байна.

Тус илтгэлтэй холбогдуулан төсөв, санхүү эдийн засгийн бодлогын байнгын хорооноос санхүү эдийн засгийн бодлогын хүрээнд тус хэлтэс нь санхүүгийн холбогдолтой хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх, төсвийн орлогыг бүрдүүлэх, батлагдсан зардлыг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах хөрөнгө оруулалтыг чанаотай, хугацаанд нь гүйцэтгэх, төрийн сангийн үйл ажиллагааг бэхжүүлсэн зэрэг үр дүнтэй ажлыг тэмдэглээд эдийн засаг нийгмийн үндсэн чиглэлийн төлөвлөлтийн чанарыг сайжруулах, эдийн засгийн албыг байгуулах, хөрөнгө оруулалтын төсөл шалгаруулах арга хэмжээг үр дүнг дээшлүүлэн хариуцлага тооцох, захиалагчдын хяналтыг дээшлүүлэх, өмч хөрөнгөнд тавих хяналтыг сайжруулах, төсвийн зардлын үр ашгийг дээшлүүлэх шаардлагатай байгаа тухай дүгнэсэн байна.

Илтгэлийг хэлэлцээд аймгийн 2008 оны төсвийн орлогын доод хязгаарыг 2428,8 сая төгрөгөөр, нийт зарлагыг 4312,4 сая төгрөгөөр, сумдын төсвийн орлогын доод хязгаарыг 844,4 сая төгрөгөөр, санхүүгийн дэмжлэгийг 1491,8 сая төгрөгөөр байхаар 8/3 дугаар тогтоолоор баталсан байна. Мөн 8/4 дүгээр тогтоолоор эрхлэх асуудлын хүрээний төсвийн ерөнхийлөн захирагч аймгийн Засаг даргатай 2008 онд нийлүүлэх бүтээгдхүүний санхүүжилтийн 16262,1 сая төгрөгийг, сумдад олгох санхүүжилт 10814,3 сая төгрөгийг тус тус сайшаан дэмжсэн байна.

Аймгийн аудитын газраас 2007 онд зохиосон ажлын тайлан, орон нутгийн 2008 оны төсвийн төсөлд болон төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлж орлого нэмэгдүүлэх талаар өгөх саналын тухай аймгийн Ерөнхий аудитор Ч.Цэрэнчимэд илтгэлдээ 2007-онд 4 ангид 341 бүтээгдэхүүн нийлүүлж 157 байгууллагын санхүүгийн тайланд аудит хийж баталгаажуулсанаар 394,9 сая төгрөгийн алдаа илэрүүлэн 43,3 хувь нь “Зөрчилгүй” стандарт, 31,2 хувь нь нэмэлт тайлбартай “Зөрчилгүй”, 23,5 хувь нь “Зөрчилтэй”, 0,6 хувь нь “Сөрөг”, 1,3 хувь нь “Дүгнэлт өгөхөөс татгалзсан” дүгнэлт өгч, тайлангийн хугацаанд 8 сум 46 байгууллагад гүцэтгэлийн аудит хийж 978,3 сая төгрөгийн зөрчил төлбөр илэрүүлсэн байна. 2008 онд орон нутгийн орлогыг лицензийн орлогоор 200,0 сая төгрөг, орон нутгийн орлогыг

16,0 сая төгрөг бүгд 216,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж төсвийн эрүүл орчинг бүрдүүлэх замаар зардал тус бүрийг 10,0 хувиар бууруулж хэмнэх санал дүгнэлт оруулсан байна.

Тус илтгэлтэй холбогдуулан төсвийн зарлагын байнгын хорооноос аудитын байгууллага дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлж төрийн аудитын чиг үүргээ хуулийн хүрээнд биелүүлж ажиллаж байгаа бөгөөд 2008 оны орлого нэмэгдүүлэх болон зардлыг бууруулах саналыг дэмжсэн дүгнэлт гаргасан байна.

Хуралдаанаар дээрх илтгэлийг хэлэлцээд 8/6 дугаар тогтоолоор аймгийн Аудитын газрыг хууль стандартын хүрээнд чиг үүргээ “хангалттай” биелүүлж ажилласан гэж дүгнэсэн байна.

Аймгийн газар зохон байгуулалтын талаар 2007 онд хэрэгжүүлсэн ажил, 2008 онд өмчлүүлж, эзэмшүүлэх газрын тухай аймгийн Газрын албаны дарга О.Батсайхан илтгэлдээ 2007-онд 4700 иргэн 792 га газрыг өмчилж гэр бүлийн хэрэгцэээнд өмчлөх газрын 28,5 хувь болж байгаа байна. Тус онд аж ахуйн зориулалтаар олгосон 14 хүний 0,51 га газрын эзэмших эрхийг хуулийн дагуу хүчингүй болгож 3 азрыг дуудлагаар 4,4 сая төгрөгөөр худалдсаныг тайлагнаад цаашид 2008 онд иргэн, аж ахуйн нэгжид дуудлага худалдаа болон төсөл сонгон шалгаруулалтаар 12,6 га, аж ахуй үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар 16,24 га, Манхан суманд давуу эрхээр газар тариалангийн зориулалтаар 4 га газрыг өмчлүүлэх, эзэмшүүлэхээр газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах, боловсон хүчнийг чадавхижуулах, ховд хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчилэх, иргэдийн өмчлөх газарт дэд бүтцийн бий болгох шаардлагатай байгааг тэмдэглэжээ.

Тус илтгэлтэй холбогдуулан хөдөөгийн бодлого байгаль орчны бодлогын хорооноос иргэдэд газар өмчлүүлэх ажил удаашралтай, түүнийг зохион байгуулан хэрэгжүүлэх талаар санаачилга муутай ажилласан, иргэд газар өмчлөх талаар өөрсдөө идэвх гаргаж ажиллахгүй хойрго хандаж байна гэж дүгнэсэн байна.

Илтгэлийг хэлэлцээд газар эзэмшүүлэх, өмчлүүлэх талаар гарч байгаа зөрчил дутагдалд дүгнэлт хийж газар зохион байгуулалтын 2008 оны төлөвлөгөөг сайтар хэлэлцэн батлахыг ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгасан 8/7 дугаар тогтоолыг баталжээ.

Аймгийн ИТХ-ын 8 дугаар хуралдаанд нийт 29 төлөөлөгчийн 22 буюу 76,0 хувь нь оролцож урилгаар 126 хүн оролцоноос төсвийн байгууллагын ажилтан 76, иргэд 50 байгаа ба хуралдаанд 27 хүн үг хэлж нийт 5 асуудал хэлэлцэн 7 тогтоол баталсан байна.

2004-2008 оны сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарын нэрс

дд	Нэр	Сумын нэр, нэр албан тушаал	Нэр	Сумын нэр, албан тушаал
1	С.Батсайхан	Алтай сумын ИТХ-ын дарга	Д.Баатарсүрэн	Алтай сумын Засаг дарга

2	Н.Бөхчулуун	Булган сумын ИТХ-ын дарга	Д.Баатарсүрэн	Булган сумын Засаг дарга
3	Д.Даваасүрэн	Буянт сумын ИТХ-ын дарга	Д.Мягмарцоож	Буянт сумын Засаг дарга
4	Д.Бальдиржамц	Дарви сумын ИТХ-ын дарга	Д.Түмэндэмбэрэл	Дарви сумын Засаг дарга
5	Д.Насанжаргал	Дөргөн сумын ИТХ-ын дарга	Х.Дэлгэрнасан	Дөргөн сумын Засаг дарга
6	Ч.Цэцэгмаа	Дуут сумын ИТХ-ын дарга	Д.Таванцэрэг	Дуут сумын Засаг дарга
7	Б.Базар	Зэрэг сумын ИТХ-ын дарга	С.Батмөнх	Зэрэг сумын Засаг дарга
8	Р.Батмөнх	Манхан сумын ИТХ-ын дарга	С.Гантөмөр	Манхан сумын Засаг дарга
9	Г.Батбаяр	Мөст сумын ИТХ-ын дарга	Л.Энхбаатар	Мөст сумын Засаг дарга
10	Л.Пүрэвсүрэн	Мөнххайрхан сумын ИТХ-ын дарга	Я.Хүрэлчулуун	Мөнххайрхан сумын Засаг дарга
11	Н.Наранцацрал	Мянгад сумын ИТХ-ын дарга	Х.Эрхэмбаяр	Мянгад сумын Засаг дарга
12	Ш.Отгонбаяр	Үенч сумын ИТХ-ын дарга	Т.Оюунбаяр	Үенч сумын Засаг дарга
13	Д.Бямбажав	Цэцэг сумын ИТХ-ын дарга	Б.Балдорж	Цэцэг сумын Засаг дарга
14	С.Гантөмөр	Чандмань сумын ИТХ-ын дарга	Т.Содномбор	Чандмань сумын Засаг дарга
15	А.Тилеуди	Ховд сумын ИТХ-ын дарга	Х.Дарьгерхан	Ховд сумын Засаг дарга
16	А.Ганбаатар	Эрдэнэбүрэн сумын ИТХ-ын дарга	Ц.Отгонбаатар	Эрдэнэбүрэн сумын Засаг дарга
17	Б.Гантулга	Жаргалант сумын ИТХ-ын дарга	Х.Батболд	Жаргалант